



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ УЛСАД СТРАТЕГИЙН ТОМООХОН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД
БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТ, ЗАСАГЛАЛЫН
ТОГТВОРТОЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: “ТУУЛЫН ХУРДНЫ ЗАМ” МЕГА ТӨСЛИЙГ ҮР
НӨЛӨӨТЭЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙДАЛ

АУДИТЫН КОД: ТЧУАГ-2026/17-ШТА-ГА



Улаанбаатар хот
2026 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор
Д.Баярсайхан

Утас: 51-263806, Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn

Бодлого, төлөвлөлт, инновацын газрын аудитын менежер
Б.Батчимэг

Утас: 51-263806, Цахим хаяг: Batchimegb@audit.gov.mn

Тусгай чиг үүргийн аудитын газрын аудитын менежер
Д.Очирсүрэн

Утас: 51-263806, Цахим хаяг: Ochirsurend@audit.gov.mn

Ахлах аудитор: **С.Одонцэцэг**
Х.Ган-Очир

Аудитор: **Д.Доржнамжим**
З.Төмөрбаатар
Д.Эрдэнэчимэг
Б.Лхагвасүрэн
М.Одгэрэл
Д.Өлзий-Утас



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/76

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Туулын хурдны зам" мега төслийг үр нөлөөтэй төлөвлөсөн байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Зам, тээврийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд тус тус хүргүүлэхийг Тусгай чиг үүргийн аудитын газар (Д.Баярсайхан)-т даалгасугай.

3.Аудитаар өгсөн албан шаардлагын мэдээллийг статистик мэдээнд бүртгэж, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг Тусгай чиг үүргийн аудитын газар (Д.Баярсайхан)-т даалгасугай.

4.Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус Үндэсний аудитын газарт тус тус ирүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (Б.Энхбаяр), Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд (Э.Бат-Амгалан), Зам, тээврийн сайд (Б.Дэлгэрсайхан), Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд (Ц.Сандаг-Очир), Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Д.Ихбаяр), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Б.Пүрэвдагва), Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга (А.Энхманлай), "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын дарга (Д.Оюунболд), Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга (Д.Одбаяр), Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга (Г.Мөнхбаатар) нарт тус тус зөвлөсүгэй.

5.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар (Ч.Цэвэгдорж), Тусгай чиг үүргийн аудитын газар (Д.Баярсайхан)-т тус тус даалгасугай.



С.МАГНАЙСҮРЭН

Z:\Tushaal\2026\EA-In A Tushaal\0630 TCHUAG-1.Docx

1526010278



Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Төлбөр, зөрчил хариуцах		Албан шаардлагын товч утга	Албан шаардлагын дүн (төгрөгөөр)
	Байгууллага	Албан тушаалтан		
1	Зам, тээврийн хөгжлийн төв Төрийн өмчит үйлдвэрийн газар	Дарга Д.Оюунболд	“Зам, тээврийн хөгжлийн төв” Төрийн өмчит үйлдвэрийн газраас “Туулын хурдны авто замын Техник, эдийн засгийн үндэслэлийн инженерийн судалгааны тайлан, (урьдчилсан зураг төсөл)”-д магадлал хийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр 06/2025 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтийг гаргасан байна.	-
2	Нийслэлийн Замын хөгжлийн газар	Дарга Б.Одбаяр	Нийслэлийн Замын хөгжлийн газраас “Туулын хурдны зам”-ын төслийн талбайд түүх, угсаатны зүйн хайгуулын тандалт, судалгааны ажил хийгдээгүй, тайлан дүгнэлт гараагүй, мөн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий байгууллагаас баталгаажуулаагүй байхад “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл” олгосон байна.	-
3	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба	Газрын дарга А.Энхманлай, Албаны дарга Г.Мөнхбаатар	Засгийн газрын 2013 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн “Хурдны зам баригдах талбайн солбицол батлах тухай” 307 дугаар тогтоолоор баталсан талбайн солбицол хэсэгт шинээр зориулалтын бус газар олголт хийхгүй байх, барилгын ажил эхлүүлэхгүй байх, солбицлын зурваст газар чөлөөлөх асуудлыг шийдвэрлэхийг Нийслэлийн Засаг даргад даалгасныг хэрэгжүүлээгүй, газар зохион байгуулалттай холбоотой гарсан шийдвэрийг Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгээгүй байна.	-

4	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар,	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Б.Пүрэвдагва,	“Туулын хурдны зам”-ын төслийн замын трассын зургийг 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга болон Газар зохион байгуулалтын албаны дарга нар зөвшилцөж баталсан бөгөөд төслийн нөлөөлөлд 112 нэгж талбар өртсөн байна. Дээрх 112 нэгж талбараас давхардсан тоогоор 10 нэгж талбар усны сан бүхий газрын Онцгой хамгаалалтын бүс, 27 нэгж талбар энгийн хамгаалалтын бүс, 33 нэгж талбар усны эх үүсвэрийн Эрүүл ахуйн хориглолтын бүс, 37 нэгж талбар хязгаарлалтын бүс, 9 нэгж талбар цахилгаан дамжуулах агаарын шугам 35 кВ, 6 нэгж талбар 110 кВ, 4 нэгж талбар ойн сан бүхий газар, 11 нэгж талбар ойн тэлэн ургах нөөц газарт тус тус олгогдсон байна.
---	---------------------------------------	--	--

---oOo---

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	3
ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	3
ЗУРАГ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	4
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	4

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	8
-------------------------------	----------

БҮЛЭГ 1. ТӨРИЙН БОДЛОГО, ШИЙДВЭР ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗАЛГАМЖ ЧАНАР, САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ ЧАНГАТГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Бодлогын баримт бичгүүдийг улс төр, эдийн засаг, нийгмийн орчны нарийн уялдааг хослуулан менежмент, хариуцлагын тогтолцоо алдагдсан байна	9
Бодлогын баримт бичгийн уялдаа, холбоо, эрэмбэ дараалал, ач холбогдлын дагуу төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай байна	10
Концесс болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээг хэрэгжилтийн шатанд өөрчлөн нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх болгон өөрчилсөн байна	11
Төслийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагааг хуульд бүрэн нийцүүлэн зохион байгуулаагүй байна	17
"Туулын хурдны зам" төслийн гэрээг хуульд нийцүүлэн байгуулаагүй, гэрээний нөхцөлийг хэлэлцэж тохиролцсон баримт байхгүй байна	19
"Туулын хурдны зам" төслийн төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлтэй байгаагаас гадна төслийг үргэлжлүүлэх эсэх нь тодорхойгүй байна	20
Төслийг төлөвлөж хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжид бүрэн нийцүүлээгүй байна	21
"Туулын хурдны зам"-ын солбицлын цэгийг дахин тооцож шийдвэрлэх шаардлагатай байна	22

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙГ ТӨЛӨВЛӨХ, ЭХЛҮҮЛЭХ, ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧИГ ХУУЛЬ ТОГТООМЖИД БҮРЭН НИЙЦЭЭГҮЙ, БЭЛЭН БАЙДАЛ ХАНГАГДААГҮЙ БАЙНА

Төслийн ТЭЗҮ, зураг төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулаагүй, хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна	27
Төслийн ТЭЗҮ, урьдчилсан зураг төсөл, төсөвт магадлал хийсэн нь хууль тогтоомжид нийцээгүй, чиг үүргийн давхардал, ойлгомжгүй нөхцөл байдлыг бий болгожээ	31
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо хангалтгүй байна	33
Төсөл эхлүүлэхэд шаардлагатай хуульд заасан бусад зөвшөөрлийг олгоогүй, дүгнэлт, тайлан гараагүй байхад ажил эхлүүлсэн байна	35

БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕГА ТӨСЛҮҮДИЙГ ТӨЛӨВЛӨХ, БАТЛАХ, ГҮЙЦЭТГЭХДЭЭ САНХҮҮГИЙН САХИЛГА БАТ, ХАРИУЦЛАГА, ИЛ ТОД БАЙДАЛ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН НИЙЦЛИЙГ ХАНГАЖ ТӨСВИЙН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Нийслэлийн төсвийн орлого тогтвортой өсөж, эерэг үзүүлэлт ажиглагдаж байгаа ч "Туулын хурдны зам" төслийн хувьд төсвийн төлөвлөлт, санхүүжилт хуульд бүрэн нийцээгүй байна	39
"Туулын хурдны зам" төслийн төсвийг батлахдаа Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг бүрэн хангуулаагүй байна	40
Төслийн төсөвт өртөг 2016 оноос хойш 4 дахин өссөн байна	43
"Туулын хурдны зам" төслийн төсөвт өртгийн тооцоолол нь урьдчилсан зураг төсөл, инженерийн төсөөлөл, томсгосон тооцоонд үндэслэсэн бөгөөд нарийвчилсан зургийн шатанд төсөвт өртөгт өөрчлөлт орох нөхцөлийг бий болгосон байна	44
Газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа газар өмчлөгч, эзэмшигч иргэн, хуулийн этгээдээс төсөл, арга хэмжээний талаарх санал асуулгыг аваагүй байна	46
Захиалагч төслийн гүйцэтгэчийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллахад анхаарах шаардлагатай байна	48

ДҮГНЭЛТ:	51
-----------------------	-----------

ЗӨВЛӨМЖ	53
----------------------	-----------

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үгс

Тайлал

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БОНХ	Байгаль орчин, ногоон хөгжил
БОНЕҮ	Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОТБУ	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ
БХБ	Барилга хот байгуулалт
БХТ	Барилгын хөгжлийн төв
ГЗБГЗЗЕГ	Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн ерөнхий газар
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар
ДЗД	Дүүргийн засаг дарга
ЗГ	Засгийн газар
ЗТЯ	Зам тээврийн яам
ЗТХТ	Зам, тээврийн хөгжлийн төв
МУ	Монгол Улс
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НИТХ	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НСХОГ	Нийслэлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газар
НЗХГ	Нийслэлийн замын хөгжлийн газар
НГЗБА	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СЯ	Сангийн яам
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
ТЧҮАГ	Тусгай Чиг үүргийн аудитын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТШББ	Тендер шалгаруулалтын барим бичиг
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
ТТАМ	Түгээмэл тархацтай ашигт малтмал
ТХХтХ	Төр, хувийн хэвшлийн тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
УГ	Усны газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХТСИ	Хот төлөвлөлт, судалгааны институт
ХБТТУтХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
DBFO	Зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, ашиглах
ВОТ	Барих, ашиглах, шилжүүлэх
ВОО	Барих, өмчлөх, ашиглах
ВООТ	Барих, өмчлөх, ашиглах, шилжүүлэх
PPA/Service	Төрийн зүгээс хувийн хэвшлийн үйлчилгээг худалдан авах хэлбэр
JICA/ЖАЙКА	Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ	НЭР
Хүснэгт №1	Авто зам, хурдны замын бүтээн байгуулалттай холбоотой Улсын бодлогын баримт бичгийн харилцан уялдааны байдал
Хүснэгт №2	Авто зам, хурдны замын бүтээн байгуулалттай холбоотой Нийслэлийн бодлогын баримт бичгийн харилцан уялдааны байдал
Хүснэгт №3	Харьцуулсан судалгаа
Хүснэгт №4	Судалгаанд хамрагдсан төслийн жагсаалт.
Хүснэгт №5	Эхний сонгон шалгаруулалтын товч мэдээлэл.
Хүснэгт №6	“Туулын хурдны зам” мега төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт тендерийн баримт бичигт орсон өөрчлөлтийн мэдээлэл
Хүснэгт №7	“Туулын хурдны зам” төслийн трасс, усны сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцаж байгаа тооцоолол
Хүснэгт №8	“Туулын хурдны зам” төслийн трасс, ой бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцаж байгаа тооцоолол
Хүснэгт №9	“Туулын хурдны зам” төслийн трасс, эрүүл ахуйн хориглолтын бүхий бүстэй давхцаж байгаа тооцоолол
Хүснэгт №10	Хориглолт, хязгаарлалт, хамгаалалтын бүсэд давхацсан нэгж талбарын тоо /давхардсан тоогоор/
Хүснэгт №11	Нийгмийн судалгаа болон Эдийн засгийн шинжилгээний тайлангийн мэдээллийн зөрүү
Хүснэгт №12	Төслийн ТЭЗҮ, урьдчилсан зураг төсөл, төсөвт хийгдсэн МЕД
Хүснэгт №13	БОННУ-ний тайланд туссан мэдээллийн шинжилгээний харьцуулалт
Хүснэгт №14	Төслийн газар чөлөөлөлтийн байдал /2026.06.09-ны байдлаар/
Хүснэгт №15	Нийслэлийн 2022-2025 оны Нийслэлийн нэгдсэн төсөв (тэрбум төгрөг)
Хүснэгт №16	Нийслэлийн 2022-2025 оны төсвийн орлогын гүйцэтгэл (тэрбум төгрөг)
Хүснэгт №17	Нийслэлийн 2022-2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан (тэрбум төгрөг).
Хүснэгт №18	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 2025, 2026 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ. (тэрбум төгрөг)
Хүснэгт №19	“Туулын хурдны зам”мега төслийн бусад санхүүжилтийн гүйцэтгэл (тэрбум төгрөг)
Хүснэгт №20	“Туулын хурдны зам” төслийн төсөвт өртгийн өөрчлөлтийн мэдээлэл (тэрбум төгрөг)
Хүснэгт №21	Туулын хурдны замын барилгын ажлын төсөвт өртгийн нэгдсэн товчоон, эзлэх хувь (тэрбум төгрөг)
Хүснэгт №22	Төсөлд олгосон нөхөх олговрын байдал
Хүснэгт №23	2013 болон 2025 оны трасст өртсөн нэгж талбарын газар чөлөөлөлтийн мэдээлэл, (тэрбум төгрөг)
Хүснэгт №24	Гадаад ажиллах хүчний бэлэн байдал
Хүснэгт №25	Тоног төхөөрөмж, машин механизмын бэлэн байдал.
Хүснэгт №26	Монгол Улсын дотоодын зах зээлээс авах хувь, хэмжээ

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

ДҮРСЛЭЛ	НЭР
Дүрслэл №1	Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа
Дүрслэл №2	Төсвийн төлөвлөлт болон төслийн хэрэгжилтийн үе шат, хугацаа.
Дүрслэл №3	Хурдны замын авто замын төслийн төлөвлөлтийн зураглал.

Дүрслэл №4	Трасс баталсан цаг хугацааны зураглал
Дүрслэл №5	ТЭЗҮ-г салбарын ангиллаар харуулбал
Дүрслэл №6	Нарийвчилсан зураг төсөл, төсөвт хийсэн зураглал, 2014-2024 он
Дүрслэл №7	БОННУ-ний тайланг баталгаажуулах үйл явц
Дүрслэл №8	"Туулын хурдны зам"-ын санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгасан байдал,(тэрбум төгрөг)
Дүрслэл №9	Төсөвт өртгийн өөрчлөлт
Дүрслэл №10	Төслийн анхны худалдан авах ажиллагааны төсөвт өртөг, холбогдох баримт бичгийн уялдаа, хугацаа

ЗУРАГ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ	НЭР
Зураг №1	Туулын хурдны замын нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдийн судалгаа, ЗГ-ын 2013.08.23-ны өдрийн 307 дугаар тогтоол
Зураг №2	"Туулын хурдны зам" төслийн трасс, усны сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцаж байгаа байдал
Зураг №3	"Туулын хурдны зам" төслийн трасс, ой бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцаж байгаа байдал
Зураг №4	"Туулын хурдны зам" төслийн трасс, эрүүл ахуйн хориглолтын бүхий бүстэй давхцаж байгаа байдал
Зураг №5	"Туулын хурдны зам" төслийн санхүүжилт баталсан шийдвэр
Зураг №6	"Туулын хурдны зам" мега төслийн барилгын ажлын зураг.
График №1	Төр, хувийн түншлэлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөө

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

ХАВСРАЛТ	НЭР
Хавсралт №1	Засгийн газрын 2013 оны 307-р тогтоолтой давхацсан трасс
Хавсралт №2	ТЭЗҮ-ийн төсөвт өртгийн үзүүлэлтийн зөрүү
Хавсралт №3	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд илэрсэн алдаа зөрчил
Хавсралт №4	Газар чөлөөлөлтийн судалгаа, сая төгрөг
Хавсралт №5	Нэгж талбарын түүхчилсэн судалгаа
Хавсралт №6	Газар чөлөөлөлтийн судалгаа
Хавсралт №7	Төслийн ажил гүйцэтгэхэд шаардлагатай авсан зөвшөөрөл
Хавсралт №8	Хориглолт, хязгаарлалт, хамгаалалтын бүсэд давхацсан нэгж талбарын дугаар, тоо

Аудит хийх үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоолоор баталсан сэдвийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2025 оны А/179 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”-ний дагуу аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

“Туулын хурдны зам” мега төслийг үр нөлөөтэй төлөвлөсөн байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтад танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Төслийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;
- Төсөл хэрэгжиж эхлэхэд бэлэн байдал бүрэн хангагдсан эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад “Туулын хурдны зам” мега төслийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн төлөвлөсөн байдал, төсөл хэрэгжиж эхлэхэд бэлэн байдал хангагдаж, хяналтыг үр дүнтэй зохион байгуулсан байдлыг хамруулж аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Зам тээврийн яам, Усны газар, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хот төлөвлөлт судалгааны институт, Нийслэлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн Замын хөгжлийн газар, “Туулын хурдны зам” ОНӨААТҮГ болон бусад холбогдох байгууллагуудыг хамруулна.

Аудитын арга зүй:

Дүгнэлт гаргах ажлыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлалд заасан арга зүйг ашиглан гүйцэтгэв.

Аудитын явцад Монгол Улсын бодлогын баримт бичиг, хөтөлбөрт тусгаж төлөвлөсөн байдал, төслийн бэлтгэл ажил хангагдсан эсэх, төслийн ТЭЗҮ, зураг төсөл, төсвийн төлөвлөлтийг хууль тогтоомж, холбогдох норм дүрэм, стандартын дагуу хийгдсэн эсэхийг тулган баталгаажуулж, захиалагч гүйцэтгэгч, холбогдох төрийн байгууллагаас ирүүлсэн баримт материал, зөвшөөрлийн талаарх мэдээллийг аудитын тайланд тусгаж дүгнэлт гаргалаа.

Аудитаар төслийн барилга байгууламжийн ТЭЗҮ/урьдчилсан зураг төсөл, сонгон шалгаруулалт, магадлалын дүгнэлтүүд, Түлхүүр гардуулах нөхцөлтэй байгуулсан гэрээнд тусгасан төсвийн бүрэлдэхүүн зэргийг тулган баталгаажуулах, биет үзлэг, хэмжилт болон зураг авалт хийх, тоон болон чанарын үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад барилга байгууламжийн ТЭЗҮ-д тусгасан төсөвт өртөгт мэргэшсэн төсөвчин, Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийн талаарх тайлан, дүгнэлтэд ШУА-ын Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн шинжээчид ажиллаж дүгнэлт гаргасан болно.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дүгнэлт гаргах ажилд дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

Хууль:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Авто замын тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Газрын тухай хууль;
- Усны тухай хууль;
- Ойн тухай хууль;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль;
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль;
- Бусад холбогдох хуулиуд.

Монгол Улсын Их хурлын тогтоол:

- УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон холбогдох бусад

Засгийн газрын тогтоол:

- Засгийн газрын 2013 оны 46 дугаар тогтоолоор баталсан “Гудамж төсөл”;
- Засгийн газрын 2013 оны 307 дугаар тогтоолоор баталсан “Хурдны зам баригдах талбайн солбицол батлах тухай”;
- Засгийн газрын 2022 оны 476 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотын “Шинэ тойрог зам”-ыг барьж байгуулах тухай”;
- Засгийн газрын 2025 оны 78 дугаар тогтоолоор баталсан “Гэрээний жишиг нөхцөл хэрэглэх тухай”;
- Засгийн газрын 2025 оны 173 дугаар тогтоолоор баталсан “Авто замын эхлэл, төгсгөлийн болон эргэлтийн цэг, солбицол батлах тухай” болон холбогдох бусад

Сайдын тушаал:

- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 08–ны өдрийн 168 дугаар тушаалын хавсралт “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам”;
- Сангийн сайдын 2023 оны А/252 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”;
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 09 дүгээр сарын 15–ны өдрийн А/116 дугаар тушаалын хавсралт “Олон улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам”;
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 14–ний өдрийн 49 дүгээр тушаалын хавсралт “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”;

- Зам, тээврийн сайдын 2024 оны А/243 тушаалын хавсралтаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм”; /ЗЗБНБД 81-013-2019/
- Сангийн сайдын 2023 оны А/259 дүгээр тушаалаар баталсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг барим бичиг-2024”;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

Хүндрэл бэрхшээл:

Аудитыг цаг хугацаанд нь гүйцэтгэхэд дараах хүндрэл бэрхшээл гарлаа. Үүнд:

✓ Төслийн хэрэгжилтийн эхний шатанд газар чөлөөлөлт, нөхөх олговор олголт, туул голын бургас шугуй, огтлох, тусгай зөвшөөрөлтэй холбоотой иргэд, аж ахуйн нэгжийн зүгээс маргаан үүссэнээс шалтгаалан барилга угсралтын ажлын явц зогсож, гүйцэтгэгч БНХАУ-руу буцсантай холбоотой тайлбар тодруулга авах, нэмэлт мэдээлэл авах боломжгүй болсон.

✓ Усны тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр оруулсан нэмэлт өөрчлөлттэй холбоотой хуулийн төсөлд санал авсан эсэх, нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэл, танилцуулга, үзэл баримтлал зэрэг холбогдох бусад баримтыг аудитын явцад гаргаж ирүүлээгүй.

✓ “Туулын хурдны зам” төслийн Олон улсын FIDIC гэрээний загварт суурилан зураг төсөл, төсөв боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх төрлөөр байгуулах гэрээний нөхцөлийг захиалагч гүйцэтгэгч талууд хэлэлцэж тохиролцсон талаарх баримтыг аудитын явцад гаргаж өгөөгүй.

✓ Төслийн үйл ажиллагааг зогсоосонтой холбоотой төслийн санхүүжилтэд олгосон 500.0 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн зарцуулалтыг тулган баталгаажуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн болно.

✓ Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн УЕПГ-ын 2026 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн шийдвэрээр АТГ, ТЕГ, ЦЕГ-ын хамтарсан ажлын хэсэг шалгаж эхэлсэнтэй холбоотой аудитын хангалттай бөгөөд зохистой нотлох зүйл цуглуулах боломж хязгаарлагдаж аудитын иж бүрэн дүгнэлт өгөх боломжгүй болсон тул Төрийн аудитын MNS 6817-5:2020 стандартын 4.2.6, 7.5.1-д заасны дагуу худалдан авах ажиллагаа болон урьдчилгаа төлбөрийн зарцуулалтын талаар хязгаарлан аудитын тайланд тусгасан болно.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Туулын хурдны зам” төсөл нь авто замын түгжрэлийг бууруулж, замын сүлжээний уртыг нэмэгдүүлэх, зүүн болон баруун чиглэлийн транзит хөдөлгөөнийг хотын төвөөр нэвтрүүлэхгүйгээр зохион байгуулах зорилготой мега дэд бүтцийн төсөл гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг болох Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, мөн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд хурдны зам барих, “Туулын хурдны зам”-ын бүтээн байгуулалтыг хийх талаар тус тус туссан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 307 дугаар тогтоол, 2022 оны Нийслэл Улаанбаатар хотын “Шинэ тойрог зам”-ыг барьж байгуулах тухай 476 дугаар тогтоол, 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 31 дүгээр хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1326 дугаартай “Хөрөнгө оруулалтыг зохион байгуулах тухай” захирамжийг үндэслэн “Туулын хурдны зам” төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэжээ.

“Туулын хурдны зам” нь Налайхын замын Улиастайн буцаж эргэх хэсгээс Дархан, Эмээлтийн замын уулзвар хүртэл 32 орчим км урттай, 6 эгнээтэй, 7 олон түвшний орц, гарцын огтлолцлуудтай, 9877.88 метр орчим урт гүүртэй 100 км/ц хурдлах боломжтой, хамгийн бага радиус 700 метр авто машины зорчих хэсгийн өргөн 6 эгнээ бүхий 25 метр, Монгол Улсад мөрдөгдөж буй Авто зам төсөллөх “БНБД 32-01-16” норм ба дүрэмд эсхүл Олон Улсын эсхүл гүйцэтгэгч өөрийн улсын стандартын дагуу хийж гүйцэтгэн Монгол Улсын норм дүрэмд нийцүүлсэн нэгдүгээр зэрэглэлийн хот доторх хурдны авто зам бөгөөд төслийн нийт төсөвт өртөг 2,384.0 тэрбум төгрөгөөр тооцоолсон байна.

“Туулын хурдны зам”-ын ТЭЗҮ, урьдчилсан зураг төслийг ЗТХТ ТӨҮГ-ын 2025 оны 05/2025 дугаартай МЭД-ээр, харин ТЭЗҮ, урьдчилсан зураг төсөл, төсвийг БХТ ТӨҮГ-ын 2025 оны 316/2025 дугаартай МЭД-ээр тус тус баталгаажуулсан байна.

Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Олон Улсын нээлттэй тендерийг 2025 онд 2 удаа зарлаж, гүйцэтгэгчээр БНХАУ-ын “China Hyway” компани шалгарч, НЗДТГ 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдөр НХААГ/20250101139 дугаартай 2,345.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй “Нийслэл Улаанбаатар хотод “Туулын хурдны зам” барих барилгын ажлын зураг төсөл боловсруулах, худалдан авах, барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-г “Хятадын ХАОЮАНЬ групп” ХХК, “Тяньжин Өүбайвэй” ХХК-тай 3 жилийн хугацаатай байгуулсан байна.

Дээрх ажил гүйцэтгэх гэрээний дагуу гүйцэтгэгчийн боловсруулсан төслийн нарийвчилсан зураг төслийг /хэсэгчилсэн 5.1 км зам/ ЗТХТ ТӨҮГ-ийн 2026 оны 80/2026 дугаартай МЭД-ээр баталгаажуулсан байна.

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

China Hyway Group Limited нь 2008 онд Хонконгт байгуулагдсан бөгөөд барилга угсралт, ерөнхий гүйцэтгэл, худалдаа, логистик, эрчим хүч, ашигт малтмал, иж бүрэн хөдөө аж ахуй зэрэг олон салбарт үйл ажиллагаа явуулдаг олон улсын төрөлжсөн групп компани юм. 2,000 гаруй нэгж барилгын техник, тоног төхөөрөмжтэй бөгөөд жилдээ 2 тэрбум ам.доллараас давсан хүчин чадалтай ажил гүйцэтгэх боломжтой.



中國昊遠
CHINA HYWAY



Тяньжин Өүбайвэй ХХК нь 2005 онд БНХАУ-ын Тяньжин Бинхай шинэ дүүрэгт бүртгэгдсэн ба хөрөнгийн хэмжээ тэрбум юаньтай байна. Одоогийн байдлаар бүртгэлтэй, шаардлага хангасан материал нийлүүлэгч 200 гаруй, логистикийн дагалдах үйлчилгээ үзүүлэгч 100 орчим ажил хийдэг байна. Уг компани нь China Hyway Group Limited-ийн хамааралтай компани байна.

<https://www.hyway-china.com/en/Content/2472799.html>

Дээрх компани нь “Туулын хурдны зам” төслийг хэрэгжүүлэхээр Монгол Улсад бүртгэлтэй “Хаоюань женерал констракшн” ГХОХХК-г хамтран эзэмшиж байна.

БҮЛЭГ 1. ТӨРИЙН БОДЛОГО, ШИЙДВЭР ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗАЛГАМЖ ЧАНАР, САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ ЧАНГАТГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Бодлогын баримт бичгүүдийг улс төр, эдийн засаг, нийгмийн орчны нарийн уялдааг хослуулан менежмент, хариуцлагын тогтолцоо алдагдсан байна

1.1 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын Төлөвлөлт төвтэй хөгжил II-р үе шат (2031-2040)-ын зорилт 5-д “Дагуул хот, тосгоныг холбосон хурдны замтай болно” гэж тусгасан бол зорилт I-ийн хүрээнд (2021-2030)-д хурдны замтай холбоотой дараах 2 үйл ажиллагаа төлөвлөсөн гэж үзэхээр байна. Үүнд:

Дүрслэл №1. Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

9.3.13. Хотын хэвтээ, босоо, тойрог чиглэлийн авто замын сүлжээ, дагуул, хаяа хотын авто замын сүлжээг барьж байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ

9.3.33. Хот, тосгоныг холбосон хурдны зам барьж байгуулна

1.2 Засгийн газрын 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн “Гудамж төсөл батлах тухай” 46-р тогтоолын 3.11-д “Баянзүрхийн товчооноос Азийн авто замын сүлжээний АН-3 тэнхлэг хүртэлх хэвтээ тэнхлэгийн хурдны зам барих” гэж, **III Хурдны зам** (2013 онд) Хэвтээ тэнхлэгийн 1. Туулын хурдны зам (Баянзүрхийн товчоо-Азийн авто замын сүлжээний АН-3 тэнхлэг) гэж тусгасан байна.

1.3 Дээрх төслийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2013 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн “Хурдны зам баригдах талбайн солбицол” батлах тухай 307 дугаар тогтоолоор хурдны зам баригдах замын чигийг баталсан байна.

1.4 Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 196 дугаар “Гудамж” төслийн нэгжийг татан буулгаж, “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийг баталж, төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах тухай” тогтоолоор дараах шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

- Тогтоолын 5-д “Гудамж төслийн санхүүжилтийн тухай” Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор “Гудамж” төсөлд хуваарилагдсан хөрөнгийг “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төсөлд шилжүүлэн санхүүжүүлэхийг Сангийн сайдад даалгаж, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл зөвшөөрсүгэй.
- Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төслийн 4.1.3. “Гудамж” дэд төсөл, 2/ батлагдсан нарийвчилсан иж бүрэн ажлын зураг төслийн дагуу Туулын хурдны замын барилгын ажлыг гүйцэтгүүлэх;

1.5 Дээрх 196 дугаар тогтоолоор байгуулсан Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төслийг баталсан шийдвэр өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр хэвээр байна.

1.6 Авто зам, хурдны замын бүтээн байгуулалттай холбоотой дараах бодлогын баримт бичгүүд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд зорилт, үйл ажиллагаа арга хэмжээ агуулгын хувьд уялдаж байгаа ч ангилал, эрэмбэ дараалал, ач холбогдол, хэрэгжүүлэх хугацаагаар уялдахгүй байна.

Хүснэгт №1. Авто зам, хурдны замын бүтээн байгуулалттай холбоотой Улсын бодлогын баримт бичгийн харилцан уялдааны байдал

Алсын хараа-2050 1 зорилт 2 үйл ажиллагаа	Шинэ сэргэлтийн бодлого 1 зорилт 1 үйл ажиллагаа	МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 0 зорилт 0 арга хэмжээ	МУ-ыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 0 зорилт 0 арга хэмжээ	МУЗГ 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 0 зорилт 0 арга хэмжээ	МУЗГ 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 1 зорилт 1 арга хэмжээ	МУ-ын хөгжлийн 2025 он төлөвлөгөө 1 зорилт 0 арга хэмжээ	МУ-ын хөгжлийн 2026 он төлөвлөгөө 1 зорилт 1 арга хэмжээ
9.3.13. 9.3.33.	4.1.5.	?	?	?	1.1.5.4.	2.2.4.16.	1.11.1.5.

Тайлбар: ● Агуулга ойролцоо ● Бүрэн уялдсан

Эх сурвалж: www.legalinfo.mn

1.7 Дээрх хүснэгтээс урт хугацааны бодлогын баримт бичигт хөгжлийн зорилт арга хэмжээг тусган, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгаагүй, богино хугацааны баримт бичигт тусгадаг нь харагдаж байна.

1.8 Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилтод Туулын хурдны зам төслийн талаар тусгаагүй бол хавсралт 2.3-т “Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний 84-т Туулын хурдны зам төслийн төсөвт өртгийг **618.5** тэрбум төгрөг” гэж тусгасан нь дунд хугацааны бодлогын баримт бичгийн уялдаагүй байдлыг харуулж байна.

1.9 Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд эрчим хүчний салбарыг хөгжүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг зохистой түвшинд хүргэх, аж үйлдвэржилтийг нэмэгдүүлэх, бүсчилсэн хөгжил, шинэ хотын бүтээн байгуулалт зэрэг эдийн засгийг тэлэх 14 мега төслийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

1.10 Мега төсөл бол зөвхөн дэд бүтэц, барилга байгууламжийн бүтээн байгуулалт биш бөгөөд улс орны хөгжлийн бодлогыг бодит үр дүнд хүргэх суурь нөхцөл болж түүнийг хэрэгжүүлэхэд зөвхөн инженерийн шийдэл хангалтгүй бөгөөд улс төр, эдийн засаг, нийгмийн орчны нарийн уялдааг хослуулан менежмент, хариуцлагын тогтолцоог шаарддаг байна.

1.11 Энэ талаар эрдэмтэн судлаачид, салбар яамдын зүгээс “Монгол Улсад мега төслийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай бодлого, эрх зүйн шинэчлэл хийх, гадаад, дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, хүний нөөцийн чадавхыг сайжруулах, ил тод байдлыг хангах, олон талт оролцогчдыг тэнцвэртэй хамруулахын тулд тухайн төслүүдийг хэрэгжүүлэхэд ашигтай оновчтой арга замыг судлах шаардлага үүсээд байна¹” дүгнэсээр иржээ.

Бодлогын баримт бичгийн уялдаа, холбоо, эрэмбэ дараалал, ач холбогдлын дагуу төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай байна

1.12 Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6.7.2а “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээс тухайн аймаг, нийслэл, хотод хамаарахыг өөрийн онцлогт нийцүүлэн тодорхойлсон байх” гэж тусгасан.

1.13 Харин Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Туулын хурдны зам төсөлтэй холбоотой зорилт арга хэмжээ тусгаагүй гэдгийг дахин дурдах нь зүйтэй байна.

1.14 НИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 24/08 дугаартай тогтоолоор “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан бодлогын баримт бичгийн хүрээнд 12 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсний 5 дугаарт “Шинэ тойрог зам, Туулын хурдны зам” барих төслийг **эхлүүлнэ** гэж тусгасан бол 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 25/111 дүгээр тогтоолын нэмэлт, өөрчлөлтөөр **хэрэгжүүлэх** болгон өөрчилжээ.

¹ Чадраабалын Баатар, Удирдлагын академи, Улсын салбарын удирдлагын тэнхимийн Ахлах багш, Магистр. Политологи сэтгүүлийн 2025 оны №24 /633/ дугаар хэвлэл.

1.15 Улмаар НЗДТГ нь **1 жилийн дараа** буюу 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/4480 дугаар “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” баталсан байна.

1.16 Дээрх үйл ажиллагааны хөтөлбөрийг өөрчилснөөр төслийн бэлтгэл ажил, санхүүжилт, шийдвэрүүд тодорхой болсон мэт харагдаж байгаа ч бодлого шийдвэр, төлөвлөлтийн уялдааг хангах асуудлыг орхигдуулдаг байна.

Хүснэгт №2. Авто зам, хурдны замын бүтээн байгуулалттай холбоотой Нийслэлийн бодлогын баримт бичгийн харилцан уялдааны байдал

НЗДТГ-ЫН 2024-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР Мега төслийн 1 зорилт	НЗДТГ-ЫН 2024-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ 1 арга хэмжээ	НИЙСЛЭЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 0 арга хэмжээ	НИЙСЛЭЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 0 арга хэмжээ	НИЙСЛЭЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 0 зорилт 0 арга хэмжээ
5	197	?	?	126

Тайлбар: ● Агуулга ойролцоо ● Бүрэн уялдсан
Эх сурвалж: НЗДТГ

1.17 Нийслэлийн харьяа “Нэгдсэн төслийн удирдлагын газар” ОНӨТҮГ-ын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 1/694 дугаартай албан бичгээр “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах тайлагнах” журмын дагуу эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, тэргүүлэх зэрэглэлээр эрэмбэлэн “Туулын хурдны зам” төсөл **5** дугаарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь тайлангийн **1.12-т** дурдсан НЗД-ын 2024-2028 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн дараалалтай нийцэж байна.

1.18 Харин “Туулын хурдны зам” төсөл өнөөдрийн байдлаар нэн тэргүүнд хэрэгжиж эхлээд байна.

1.19 Энэ нь Нийслэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хүрээнд бодлогын баримт бичгүүдийн уялдаа хангагдаагүй², Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн шаардлагыг орхигдуулсан гэж үзэхээр байна.

1.20 Бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилго, зорилтыг уялдаа холбоотой, эрэмбэ дараалалд үндэслэн, хууль эрх зүйн шаардлагыг бүрэн ханган хэрэгжүүлэх нь дэд бүтцийн томоохон төслүүдийн үр нөлөөг сайжруулах, төсвийн үр ашигтай зарцуулалтыг хангах, улс орны тогтвортой хөгжлийг дэмжих чухал суурь нөхцөл болохыг анхаарах хэрэгтэй байна.

Концесс болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээг хэрэгжилтийн шатанд өөрчлөн нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх болгон өөрчилсөн байна

1.21 “Туулын хурдны зам” мега төсөл нь Гудамж төслөөс эхлэлтэй бол Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Улаанбаатар хотын Шинэ тойрог зам-ыг барьж байгуулах тухай” 476 дугаар тогтоолоор Туулын хурдны зам гүүрэн байгууламж барьж байгуулах тухай Улаанбаатар хотын Захирагчид даалгажээ.

1.22 Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 253 дугаар тогтоолын 24¹⁸-д “Шинэ тойрог зам” төслийн урд хэсэг “Туулын авто зам” төсөл”-ийг концессоор хийж хэрэгжүүлэхээр тусгасан байна.

1.23 Мөн Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит хуралдаанаар Нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих төсөл, арга хэмжээний талаар хэлэлцэн “Туулын хурдны зам” болон Шинэ тойрог замын ажлыг эхлүүлэх төслийг төр

² ХБТТутХ-ийн 5.1.3.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх, 6.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь дэвшүүлсэн зорилго, зорилтоо хангахад чиглэгдсэн, харилцан уялдаа бүхий дараах төрөлтэй байна

хувийн хэвшлийн түншлэлээр барьж байгуулах олон улсын нээлттэй тендерийг 2024 он 08 дугаар сард багтаан зарлах, зэрэг бэлтгэл ажлыг хангахаар хэлэлцсэн байна.

1.24 Улмаар НИТХ-ын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/01 дүгээр тогтоолоор Төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийслэлд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад тус төсөл багтсан байна.

1.25 Концессын тухай хууль 2010 оноос хойш хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр хүчингүй болж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар мөн өдрөөс эхлэн үйлчилж эхэлсэн байна.

1.26 Концессын тухай хууль хэрэгжиж байх хугацаанд дараах зохицуулалтууд маргаан дагуулсаар иржээ. Үүнд:

- **Институтийн тогтворгүй байдал** /2010 оноос хойш концессын асуудал хариуцсан 7 байгууллага дамжсан/
- **Хууль зөрчсөн сонгон шалгаруулалт** /Концесс эзэмшигчийг сонгох аргыг тодорхойлох, шалгаруулалт явуулахдаа холбогдох хууль, журмыг зөрчсөн/
- **Хуулийн шаардлага хангаагүй шууд гэрээ** /Нийт гэрээний 60% нь шууд гэрээ/
- **Хуулийн шаардлага хангаагүй төслийн жагсаалт** /Төслүүдийн үр ашиг, ач холбогдлыг тооцоогүй ЗГ-аар батлуулсан/
- **Төсөвт ихээхэн ачаалал үүссэн** /Б-Ш төрлийн 37 төслийн нийт эргэн төлөлт 2 их наяд /2016-2025 он/
- **Хуульд заасан журам, аргачлал батлагдаагүй** /Концессын хуульд заасан холбогдох журам, аргачлалууд батлагдаагүй байх төслүүд хэрэгжсэн/
- **Салбар яамдын оролцоогүй** /Сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавихад салбарын яамд оролцдоггүй/
- **Төсөвт үзүүлэх нөлөө, эрсдэлийг тооцдоггүй** /Гэрээ байгуулах төслүүдийн төсөвт үзүүлэх нөлөө, эрсдэлийг тооцдоггүй, СЯ-ны оролцоо байхгүй/³

1.27 Концессын тухай хуулийн хүрээнд 25.5 их наяд төгрөгийн 60 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн бол Төр, хувийн хэвшлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр төсвийн ачаалал буурсан нь дараах графикаас харагдаж байна.

График №1. Төр, хувийн түншлэлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөө



Эх сурвалж: Сангийн яам

Тайлбар:

- “Барих-Шилжүүлэх” гэрээтэй 40 төслийн 2.2 их наяд төгрөгийн гэрээ байгуулсан, 1.6 их наяд төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн.
- “Барих-Ашиглах- Шилжүүлэх” гэрээтэй 20 төсөл /23.3 их наяд төгрөг

³ Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага ба төр, хувийн хэвшлийн түншлэл /СЯ, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал/

1.28 Хэрэв энэхүү төслийг Засгийн газрын тогтоолын дагуу Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журмын хүрээнд хэрэгжүүлсэн бол төлөвлөлт, ил тод байдлыг хангасан, хувийн хэвшлийн санхүүжилтийн оролцоотой, гүйцэтгэлд суурилсан төлбөрийн механизмтай, эрсдэлийн хуваарилалт тэнцвэртэй тодорхой байх байжээ.

1.29 Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхэд дараах асуудлууд хуульд нийцсэн, тодорхой шалгууртай, ил тод байдлыг хангасан зорилгодоо нийцсэн гэрээ байгуулах боломжтой байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөлд тавих шалгуураас

Урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ хийх

- Төслийн нийгмийн ач холбогдлын талаарх мэдээлэл;
- Төслийн эдийн засгийн үр ашгийн талаарх мэдээлэл;
- Төсөл хэрэгжүүлэх салбарын хууль, эрх зүйн орчны талаарх мэдээлэл;
- Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан байдлын талаарх мэдээлэл;
- Төслийн дэд бүтцийн хэрэгцээний мэдээлэл;
- Санхүү, хөрөнгө оруулалтын тооцоо;
- Санхүү, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ;
- Түншлэлийн төслийн **урьдчилсан** болон **нарийвчилсан** техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах;
- Түншлэлийн төслийн эрсдэлийг судалж, тодорхойлох.
- Хууль зүйн дүн шинжилгээ, нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ хийж баталгаажуулсан байх;
- Төслийн үйл ажиллагаанд шаардлагатай Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдох зөвшөөрлийг тодорхойлсон байх;
- Төслийн нийт зардлыг тухайн төслийн үе шатанд шаардлагатай бүх зардлыг хамааруулан нэгдсэн дүнгээр тодорхойлсон байх;
- Байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлсэн байх;
- Түншлэлийн төрөл, орон нутгийн төсөөс санхүүжүүлэх санхүүжилтийн хуваарь, хэрэглэгчийн төлбөр, хураамжийн судалгаа, зардал, үр ашгийн тооцоолол, төслийн санхүүжилтийн мэдээлэл;
- Төслийн барилга байгууламж болон үйл ажиллагааны тодорхойлолт;

Хяналтын хүрээнд

- Аймаг, нийслэлийн Засаг дарга нь түншлэлийн гэрээ, түншлэлийн төслийн хэрэгжилтийн мэдээллийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 51.1-д зааснаас бусад тохиолдолд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нийтэд мэдээлж, ил тод байдлыг хангаж ажиллана.
- Хууль тогтоомжид заасан хүрээнд нийтийн зориулалттай дэд бүтцийн барилга байгууламжийн ашиглалтад салбарын асуудал эрхэлсэн холбогдох төрийн байгууллага болон тухайн салбарын мэргэжлийн байгууллага хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- Төрийн аудитын байгууллага Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хэрэгжилт, түншлэлийн төслийн төлөвлөлт, хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалт, түншлэлийн төслийн хэрэгжилт болон гэрээний биелэлтэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, аудитын тайланг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

Түншлэлийн эх төслийг боловсруулах

- Мөнгөний үнэ цэний шинжилгээ;
- Төслийг хэрэгжүүлэх түншлэлийн төрөл, **гэрээний хэлбэр**, төсөл хэрэгжүүлэх хугацаа.
- Түншлэлийн эх төсөлд техник, эдийн засаг, санхүү, хууль, эрх зүй, нийгэм болон байгаль орчны нөлөөллийн үндэслэл, нотолгоо, тоон баримт зэргийг тусгана.
- Төслийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл, мөн түншлэлийн гэрээний дагуу төсөвт шууд болон шууд бус төлбөрийн үүрэг, хариуцлага бий болгох эсэхийг тооцно.

Зөвлөх үйлчилгээ


- Түншлэлийн төслийн техник хяналтын гэрээг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээ;
- Түншлэлийн гэрээнд заасан тохиолдолд төсөл хэрэгжих хугацаанд хувийн хэвшлийн түншлэгчийн үйл ажиллагаа, хэрэгжилт, гүйцэтгэлд гэрээний дагуу хяналт тавих, хөндлөнгийн үнэлгээ хийлгэх зөвлөх үйлчилгээ;
- **Зөвлөх үйлчилгээний үйл ажиллагаа**
- Түншлэлийн төслийн дүн шинжилгээг хийх;
- Түншлэлийн төслийн **урьдчилсан** болон **нарийвчилсан** техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах;
- Түншлэлийн төслийн эх хувийг боловсруулах;

Гэрээний хүрээнд

- Түншлэлийн гэрээ байгуулагдсан даруйд тухайн түншлэлийн гэрээ болон дагалдах гэрээний хуулбарыг түншлэлийн мэдээллийн нэгдсэн санд байршуулах арга хэмжээ авч, олон нийтэд мэдээлэх.
- Төрийн түншлэгч нь түншлэлийн төслийн бүх үе шатанд түншлэлийн гэрээнд заасан хяналтын эрхийг хэрэгжүүлнэ.
- Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас гэрээ байгуулах эрх олгосон шийдвэр;

1.30 Томоохон төсөл нь их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг, олон оролцогчтой, урт хугацаатай, хэрэгжилт нь ихэвчлэн тодорхойгүй орчинтой байдаг тул түүнийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд институтийн болон эдийн засгийн онолын суурь олголт зайлшгүй шаардлагатай бөгөөд мега төслийн төлөвлөлт, хэрэгжилтэд чухал үүрэг гүйцэтгэдэг байна.⁴

Дүрслэл №2. Төсвийн төлөвлөлт болон төслийн хэрэгжилтийн үе шат, хугацаа.



Эх сурвалж: Сангийн яам

1.31 Мөн мега төслийг хэрэгжүүлэхэд эрсдэлийн хуваарилалт нь санхүүгийн, техникийн, зах зээлийн болон улс төрийн эрсдэлийг аль тал хамгийн сайн удирдаж чадах вэ гэдгийг чухалчилж авч үздэг байна. Эрсдэлийг нэг талд төвлөрүүлэх нь төсөл амжилтгүй болох магадлалыг нэмэгдүүлдэг байна.⁵

Том төслүүдийн **85%** нь анх төлөвлөсөн хугацаа болон төсвөөсөө хэтэрдэг, мөн **1/3** нь л амжилтад хүрдэг гэсэн судалгаа байдаг (McKinsey, 2016)-аас үзэхэд том төслүүдтэй холбоотой эрсдэлүүд нь эдийн засагт голлон **сөрөг нөлөө** үзүүлэх хандлагатай байдаг.

1.32 Судлаачид мега төслүүдийн үр нөлөө нь эдийн засгийн шинэ чиглэлийг бий болгох, логикийн интеграци, хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх, шинж үйлдвэрлэлийн тогтолцоо үүсгэх зэрэг системийн өөрчлөлтийг бий болгодгийг тогтоожээ.⁶

1.33 Иймд энэхүү шаардлагуудыг нэгэн зэрэг хангаж чадахуйц хууль эрх зүйн орчин шаардлагатай байдаг бөгөөд дэлхийн улс орнууд мега төслийг ихэвчлэн төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлдэг байна.

1.34 Төр, хувийн хэвшлийн түншлэл нь мега төслийн санхүүгийн ачааллыг жигд хуваарилах, эрсдэлийг бууруулах, менежментийн чадавхыг нэмэгдүүлэх, дэд бүтэц хийгээд төслийн бүтээн байгуулалтын зохистой түвшин хангадаг арга зам болох нь практик дээр нотолсон байна.

1.35 Монгол Улсад төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан мега төслийг хэрэгжүүлэхэд ашиглагдах хамгийн өндөр боломжтой төрлүүдийн харьцуулалтыг дараах байдлаар хийжээ⁷

⁴ Чадраабалын Баатар, Удирдлагын академи, Улсын салбарын удирдлагын тэнхимийн Ахлах багш, Магистр. Политологи сэтгүүлийн 2025 оны №24 /633/ дугаар хэвлэл. 3-р хуудас

⁵ Arrow, 1971

⁶ Zhou, 2017

⁷ Чадраабалын Баатар, Удирдлагын академи, Улсын салбарын удирдлагын тэнхимийн Ахлах багш, Магистр. Политологи сэтгүүлийн 2025 оны №24 /633/ дугаар хэвлэл. 11-р хуудас

Хүснэгт №3. Харьцуулсан судалгаа

Төрөл	Үндсэн агуулга	Хөрөнгө оруулалт	Эзэмшил, ашиглалтын эрх	Эрсдэлийн хуваарилалт	Монгол Улсад тохиромжтой салбар
Барих- Ашиглах Шилжүүлэх (BOT)	Хувийн хэвшил төслийг хэрэгжүүлэн тодорхой хугацаанд ашиглаад төрд шилжүүлнэ.	Хувийн хэвшил	Ашиглалтын хугацаанд хувийн хэвшилд	Санхүү, ашиглалтын эрсдэл хувийн хэвшилд төвлөрнө.	Авто зам, гүүр, эрчим хүчний үйлдвэрлэл, нисэх онгоцны буудал
Барих-Өмчлөх-Ашиглах (BOO)	Хувийн хэвшил төслийг хэрэгжүүлж, эзэмшин, байнга ашиглана.	Хувийн хэвшил	Эзэмшил, ашиглалт бүрэн хувийн хэвшилд	Төрийн зүгээс хүлээх эрсдэл бага, зах зээлийн эрсдэл өндөр байдаг.	Авто зам, ус хангамж, дэд бүтэц
Барих-Өмчлөх-Ашиглах-Шилжүүлэх (BOOT)	BOT-той төстэй боловч гэхдээ ашиглал.	Хувийн хэвшил	Түр хугацаанд хувийн хэвшилд	Урт хугацааны санхүүгийн эрсдэл хувийн хэвшилд шилждэг.	Авто зам, гүүр, дэд бүтэц
Зураг төсөл боловсруулах-Барих-Санхүүжүүлэх-Ашиглах (DBFO)	Төслийн бүхий үе шатыг хувийн хэвшил хариуцна.	Хувийн хэвшил	Гэрээгээр тодорхойлно	Эрсдэлийг гэрээгээр нарийн хуваарилна.	Авто зам, ус хангамж, дэд бүтэц
Төрийн зүгээс хувийн хэвшлийн үйлчилгээг худалдан авах (PPA/Service)	Хувийн хэвшил шаардлагатай барилга, байгууламж, дэд бүтцийг барьж ашиглана. Харин төр үйлчилгээг нь худалдан авна.	Хувийн хэвшил	Хувийн хэвшилд	Эрэлт, орлогын эрсдэлийг төр хариуцна.	Сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үйлдвэрлэлд

Эх сурвалж: Политологи сэтгүүлийн 2025 оны №24

1.36 Эдгээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн төрлүүдийн аль нь ч давуу болон сул талтай бөгөөд Монгол Улсын хувьд тухайн төслийн хэрэгжиж байгаа салбар, стратегийн ач холбогдол, төрийн институтийн чадавхтай уялдуулан зохистой төрлийг оновчтой сонгох нь мега төслийг үр ашигтай хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болох юм.

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын судалгаанаас толилуулахад:

1.37 Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка)-гийн Монгол Улс Улаанбаатар хотын зам тээврийн дэд бүтцийг бэхжүүлэх суурь судалгаа (QCBS) эцсийн тайланг 2022 оны 02 дугаар сард хийжээ.

Судалгаагаар Жайка нь замын хөдөлгөөний судалгаанд үндэслэн өнөөгийн байдалд дүгнэлт хийн ирээдүйн эрэлтийг тодорхойлон, УБЕТ 2020 болон НЗДТГ шинэчлэн боловсруулж хот төлөвлөлт, хотын тээврийн бодлого, төлөвлөлтөд тулгуурлан УБ хотын зам тээврийн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудалд дүгнэлт хийж ирээдүйн дүр зургийг хэлэлцэн, өнөөгийн асуудлыг шийдвэрлэх арга замыг цэгцэлж, тээврийн дэд бүтцийг бэхжүүлэх цаашдын хамтын ажиллагааны чиг хандлагыг тодорхойлох зорилготой байна.

1.38 Судалгаагаар Нийслэл Улаанбаатар хотод хэрэгжүүлэх төслийг хөгжлийн үр өгөөж, хөрөнгө оруулалтын үр ашиг, хамтран ажиллах байгууллагын ур чадвар, байгаль орчин, нийгэмд ээлтэй эсэхийг харгалзан он цагийн дараалалтай эрэмбэлснийг дараах жагсаалтаар харуулж байна.

Хүснэгт №4. Судалгаанд хамрагдсан төслийн жагсаалт.

1)Хөдөлгөөнийг хуваарилах үндсэн зам болон холбоос замууд барих	А.	Хурдны зам/Гол зам	2025	2030	2040	Богино
	A.1	Туул голын хурдны зам+тойруу зам			●	
	A.2	Хойд хэсгийн гэр хорооллын зам		●	●	
	В.	Их багтаамжтай нийтийн тээвэр	2025	2030	2040	

2) Үндсэн нийтийн тээврийн систем хөгжүүлэх	B.1	East-West line (Нарны зам)			●	
	B.2	East-West line (Энхтайвангийн өргөн чөлөө)			●	
	B.3	North South line			●	
	B.4	Нийслэлийн санал болгож буй шугам East-West			●	
	B.5	Нийслэлийн санал болгож буй шугам North- South (West side)			●	
	B.6	Нийслэлийн санал болгож буй шугам North- South (East side)			●	
	C.	Автобус тээвэр	2025	2030	2040	
	C.1	Автобусны тусгай эгнээ		●	●	
	C.2	Автобусны дэвшилтэт терминал	●	●	●	
1) Хөдөлгөөнийг хуваарилах үндсэн зам болон холбоос замууд барих	D.	Туслах зам	2025	2030	2040	
	D.1	Нисэх онгоцны буудлын хойд хэсгийн холбоос зам		●	●	
	D.2	Ногоон өргөн чөлөө+Өргөтгөл		●	●	✓
	D.3	Ард Аюуш өргөн чөлөөг уртасгах		●	●	
	D.4	Ажилчны зам гүүр		●	●	✓
	D.5	Нарны зам зүүн хэсэг уртасгах		●	●	
	D.6	Тойруу зам		●	●	
3) Замын түгжрэлийн хүчин зүйлийг арилгах	E.	Уулзвар	2025	2030	2040	
	E.1	Зүүн 4 замын уулзвар	●	●	●	
	E.2	Саппоро уулзвар	●	●	●	✓
	E.3	17 сургуулийн уулзвар	●	●	●	
	E.4	Баруун 4 замын уулзвар	●	●	●	
	E.5	Баянбүрдийн уулзвар	●	●	●	✓
4) ТХА-аар хүний нөөцийн чадавх хөгжүүлэх, удирдлага, технологи сайжруулах	F.	Техникийн хамтын ажиллагаа	2025	2030	2040	
	F.1	Нийтийн тээврийг сайжруулах хөтөлбөр		●	●	
	F.2	Зам тээврийг сайжруулах технологи бэхжүүлэх төсөл		●	●	
	F.3	Хотын ус зайлуулах байгууламжийн төлөвлөлт, засвар арчлалтын технологи		●	●	
3) Замын түгжрэлийн хүчин зүйл арилгах	G.	Замын хөдөлгөөний удирдлага	2025	2030	2040	
	G.1	Автомат мэдрэгчтэй гэрлэн дохио	●	●	●	✓

Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг

1.39 Дээрх судалгааны үр дүнд **D2.Ногоон өргөн чөлөө+Өргөтгөл, D4.Ажилчны зам гүүр барих төсөл, E2.Саппоро уулзварыг олон түвшинт болгох, E5.Баянбүрд уулзварыг олон түвшинт болгох, G1.Автомат мэдрэгчтэй гэрлэн дохио нэвтрүүлэх** төслүүд сонгогдсон байна.

Дүрслэл №3. Хурдны замын авто замын төслийн төлөвлөлтийн зураглал.

Алсын хараа- 2050 Төлөвлөлт төвтэй хөгжил II-р үе шат (2031-2040)-ын зорилт 5-д “Дагуул хот, тосгоныг холбосон хурдны замтай болно”	Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайка Судалгааны А1.Туул голын хурдны зам+тойруу зам нь цаг хугацааны хувьд 2040 онд хэрэгжихээр төлөвлөсөн байна.	"Нэгдсэн төслийн удирдлагын газар" ОНӨТҮГ Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, тэргүүлэх зэрэглэлээр Туулын хурдны зам төсөл 5 дугаарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна
--	---	--

Эх сурвалж: Аудитын баг

1.40 Дээрх дүрслэлд харуулснаар Улаанбаатар хотын төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, газар зохион байгуулалт, авто замын төслийн төлөвлөлтийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, мэдээллийн нэгдсэн системтэй, салбар хоорондын уялдааг хангасан байдлаар төлөвлөсөн бол төслийн бэлтгэл ажил бүрэн хангагдах боломжтой байжээ.

1.41 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн батлагдсан журмуудад томоохон дэд бүтцийн төслүүдийг урьдчилсан үнэлгээ, техник-эдийн засгийн үндэслэл, санхүүгийн тооцоолол, эрсдэлийн хуваарилалт, сонгон шалгаруулалт, гүйцэтгэлийн хяналтын үе шаттай, нэгдсэн тогтолцоонд үндэслэн хэрэгжүүлэхээр зохицуулсан байна.

1.42 Уг зохицуулалт нь төслийн төлөвлөлтийн чанарыг сайжруулах, санхүүгийн сахилга батыг хангах, хэрэгжилтийн ил тод байдал, хяналтыг нэмэгдүүлэх давуу талыг бүрдүүлсэн гэж үзэхээр байна.

1.43 Концесс болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлэхээр баталсан төслийг нийслэлийн төсвийн санхүүжилтэд шилжүүлэх үндэслэл холбогдох шийдвэрийг хуульд нийцүүлэн албан ёсоор өөрчилж, хүчингүй болгосон шийдвэргүйгээр хэрэгжүүлж эхэлсэн нь санхүүгийн болон гэрээний хэрэгжилт, захиалагчийн хяналтын механизмыг бүрэн ашиглах боломжийг хязгаарласан гэж үзэхээр байна.

1.44 Энэ нь Төсвийн тухай хуулийн 28,29 мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн суурь зарчим алдагдах, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн хууль ёсны байх, үндэслэлтэй байх, ил тод байх, мөн хуулийн 40, 41-р зүйлд заасны дагуу өмнөх шийдвэрийг өөрчлөх зэрэг заалттай нийцэхгүй байна.

Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хуульд бүрэн нийцүүлэн зохион байгуулаагүй байна

1.45 Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлын хүрээнд Нийслэлээс 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр дараах шийдвэрийг гаргасан байна.

- Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” А/77 дугаар захирамж;
- НХААГ-ын даргын “Үнэлгээний хороо байгуулах тухай” А/14 дүгээр тушаал;
- Үнэлгээний хороо хуралдаж тендер шалгаруулалтын баримт бичгийг хэлэлцэн анхны төсөвт өртөг 1,964.8 тэрбум төгрөг, 2025 онд санхүүжүүлэх дүн нь 538.6 тэрбум төгрөг гэж баталсан;
- Төслийн худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан

1.46 Сонгон шалгаруулалтыг зарласнаас хойш Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн “Гэрээний жишиг нөхцөл хэрэглэх тухай” 78 дугаар тогтоол батлагдсантай холбоотой 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр, 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр тус тус ТШББ-т 2 удаа өөрчлөлт оруулж, 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр нээсэн байна.

1.47 Сонгон шалгаруулалтад нийт 3 оролцогч үнийн санал ирүүлсэн боловч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 26 дугаар зүйлийн 26.10 дахь хэсэгт заасны дагуу шаардлага хангасан оролцогч ирээгүй гэж үзэн дахин зарлахаар шийдвэрлэсэн байна.

Хүснэгт №5. Эхний сонгон шалгаруулалтын товч мэдээлэл.

№	Шалгуур		"Поли Чангда инженеринг" ХХК	"Шань дун лу чиау" ХХК	"Лун Зянь Рөүд энд бридж" ХХК
1	Тендерийн үнэ		1,571.5 тэрбум	1,964.8 тэрбум	3,553.0 тэрбум
2	Чадавхын шаардлага хангасан эсэх	Санхүүгийн	Тийм	Тийм	Тийм
		Техникийн чадавх, туршлага	Үгүй	Үгүй	Үгүй
3	Шаардлага хангасан эсэх		Үгүй	Үгүй	Үгүй

Тэмдэглэл	1.Гадаадын этгээд...баримт бичгийг, баталгаат орчуулга тодорхойгүй байна. 2. Төсвийг ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу ТЭЗҮ, зураг төсөл, норм нормативын зардлыг зөрүүтэй тооцсон.	1. Төсвийг ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу ТЭЗҮ, зураг төсөл, норм нормативын зардлыг зөрүүтэй тооцсон.	1. Тендерийн үнэ төсөвт өртгөөс хэтэрсэн.
-----------	--	---	---

Эх сурвалж: НХААГ-аас ирүүлсэн “Туулын хурдны зам”-ын ажил (Улаанбаатар хот), НХААГ/20250101139 ХАА-ны архивын баримт Боть-1, 2.

1.48 Тендерт оролцогчид сонгон шалгаруулалттай холбогдуулан “Поли Чангда инженеринг” ХХК /Poly Changda Engineering Co.,Ltd./, “Шань дун лү чиау” ХХК /Shandong Luqiao Group Co.,Ltd./, “Лун Зянь Рөүд энд бридж” ХХК /Longjian road&bridge Co.,Ltd./-иас Сангийн яаманд 2025 оны 7 дугаар сарын 08, 09-ний өдрийн хооронд гомдол гаргасан бөгөөд Сангийн яам дараах шалтгаанаар гомдлыг хүлээн авахаас татгалзаж буцаасан байна. Үүнд:

- “Поли Чангда инженеринг” ХХК-д 2025 оны 7 дугаар сарын 22-ны өдөр 02/7021 тоот албан бичгээр “...захиаалагчийн шийдвэрийг хавсаргаж ирүүлээгүй байх тул...журмын 4.6-д заасны дагуу...”,
- “Шань дун лү чиау” ХХК-д 02/7024 дугаартай албан бичгээр “...гарын үсэг зурсан Лин Цуньёу нь...компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд болохыг нотлох баримт хавсаргаж ирүүлээгүй тул...журмын 2.4-т заасны дагуу...”,
- “Лун Зянь Рөүд энд бридж” ХХК-д 2025 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 02/7091 дугаартай албан бичгээр “...Кан Вэньбинд олгосон итгэмжлэлийн хүчинтэй хугацаа 2025 оны 7 дугаар сарын 01-ний өдөр дуусгавар болсон байх тул...журмын 2.4-т заасны дагуу гомдлыг буцааж байна”

1.49 Улмаар 2 дахь удаа буюу 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зарлаж 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 13:10 минутад нээсэн байна. Уг тендерт нийт 4 оролцогч үнийн санал ирүүлснээс 3 оролцогч шаардлага хангаагүй бол “Хятадын Хаоюань групп” ХХК болон “Тяньжин ӨүБайВэй” ХХК-иудын түншлэлтэй оролцогчийг хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн гэж үзэж шалгаруулсан байна.

1.50 НХААГ-ын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр 03/2052 тоот албан бичгээр гэрээ байгуулах эрх олгож 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдөр гэрээг байгуулсан байна. /Хүснэгт №4/

Хүснэгт №6. “Туулын хурдны зам” мега төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт тендерийн баримт бичигт орсон өөрчлөлтийн мэдээлэл

№	Өгөгдлийн хүснэгт	2025.01.27-нд зарласан тендер /сүүлийн хувилбар/	2025.04.23-нд зарласан тендер /сүүлийн хувилбар/
1	Төсөвт өртөг ТШЗ 2.1	1,964.8 тэрбум төгрөг	2,384.0 тэрбум төгрөг
2	ТШЗ 18.1	Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 (2024) онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна"	Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2022, 2023, 2024 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна"
3	ТШЗ 19.1.3	Сүүлийн 15 жилийн хугацаанд тус бүр 250 сая ам.доллараас доошгүй үнийн дүнтэй 5 ажлыг хийж гүйцэтгэсэн байх, эдгээр 5 ажлаас 3-аас доошгүй ажил нь -20 градусаас хүйтэн уур амьсгалтай газарт гүүрэн байгууламж бүхий төсөл, арга хэмжээ байна	Сүүлийн 15 жилийн хугацаанд тус бүр 150 сая ам.доллараас доошгүй үнийн дүнтэй 3 ажлыг хийж гүйцэтгэсэн байх Эдгээр 3 ажлаас 1 ажил нь авто зам, замын байгууламжийн ажил -20 градусаас хүйтэн уур амьсгалтай газарт гүйцэтгэсэн байна.

Эх сурвалж: НХААГ-аас ирүүлсэн “Туулын хурдны зам”-ын ажил (Улаанбаатар хот), НХААГ/20250101139 ХАА-ны архивын баримт Боть-1, 2.

1.51 Гэвч "Хятадын Хаоюань групп" ХХК болон "Тяньжин ӨүБайВэй" ХХК-иудын түншлэлтэй оролцогчийн ирүүлсэн тендерийн баримт бичгийг өмнөх сонгон шалгаруулалт болон бусад оролцогчийн баримт бичигтэй харьцуулан тулган баталгаажуулж дүн шинжилгээ хийж үзэхэд дараах зөрчил гарсан байна. Үүнд:

- Төсвийг ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу ТЭЗҮ, зураг төсөл, норм нормативын зардлыг зөрүүтэй тооцсон;
- Эхний тендерийн баримт бичиг, өгөгдлийн хүснэгтэд "гэрээний үнэд тохируулга хийхгүй тогтмол үнийн гэрээ байна" гэж заасан боловч FIDIC гэрээнд үнийн дүн өөрчлөгдөж тохируулга хийгдэж болохуйц байдлаар тусгасан байна;
- Харин 2 дахь тендерийн өгөгдлийн хүснэгтэд энэ талаар огт тусгаагүй боловч тендер шалгаруулалтын зааварчилгаанд "гэрээний үнэд тохируулга хийхгүй, хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ" гэж тусгасан байна.

1.52 Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.11⁸-д заасантай нийцэхгүй байна.

1.53 Хоёр дахь удаагийн тендерийг нээхээс өмнө буюу 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр захиалагчийн хяналт тавих байгууллагаас залруулга оруулах хүсэлт ирүүлсэнтэй холбоотойгоор ТШЗ 19.2.3-т өөрчлөлт оруулсан байх бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 27-ний өдөр тендерийг нээжээ.

1.54 Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.6-т "Захиалагч тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж, цахим системд нийтэлсэн бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана" гэж заасантай нийцэхгүй байна.

1.55 Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулаагүй байна.

1.56 Аудитын явцад төслийн сонгон шалгаруулалттай холбоотой Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн УЕПГ-ын 2026 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн шийдвэрээр АТГ, ТЕГ, ЦЕГ-ын хамтарсан ажлын хэсэг шалгаж эхэлсэнтэй холбоотой аудитын хангалттай бөгөөд зохистой нотлох зүйл цуглуулах боломж хязгаарлагдаж аудитын иж бүрэн дүгнэлт өгөх боломжгүй болсон тул Төрийн аудитын MNS 6817-5:2020 стандартын 4.2.6, 7.5.1-д заасны дагуу тухайн асуудлыг хязгаарлан аудитын тайланд тусгасан болно.

"Туулын хурдны зам" төслийн гэрээг хуульд нийцүүлэн байгуулаагүй, гэрээний нөхцөлийг хэлэлцэж тохиролцсон баримт байхгүй байна

1.57 "Туулын хурдны зам" төслийг концесс болон төр, хувийн хэвшлийн түншлэлээр анхлан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн талаар тайлангийн 1.22, 1.23-т тусгасан.

1.58 Харин Улаанбаатар хотын захиргаа болон Хонг-Конгын "ХаоЮань групп" (HaoYuan Group LLC) хооронд НХААГ/20250101139 дугаартай гэрээг 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Олон Улсын зөвлөх инженерүүдийн холбооны FIDIC стандарт загварт суурилсан зураг төсөл боловсруулах, барих, авах шилжүүлэх нөхцөлтэй гэрээ байгуулжээ.

1.59 Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн "Гэрээний жишиг нөхцөл хэрэглэх тухай" 78-р тогтоолоор олон улсын /FIDIC/-ны гэрээний жишиг нөхцөлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэглэхийг даалгасан.

1.60 Харин НЗД-ын 2025 оны 02 сарын 25-ны өдрийн А/277 тушаалаар Томоохон /мега/ төслүүдийн жагсаалт баталж, хэрэгжилт хангуулах тухай 21 төсөлд "Туулын хурдны зам" төслийг багтааж баталсан байна.

⁸ 11.1.Захиалагч гэрээний хэрэгжилтийн явцад гүйцэтгэгчээс үл хамаарах шалтгаанаар бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлс өөрчлөгдсөнтэй холбоотойгоор гэрээний үнийг тохируулах бол тохируулга хийх нөхцөл, аргачлалыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана

1.61 Гэтэл захиалагч тал Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг Олон улсын гэрээний жишиг загвартай уялдуулж хууль тогтоомжид нийцүүлэх байснаас гадна төслийг эхлүүлэх эрх олгогдоогүй байхад гэрээ байгуулж төслийг эхлүүлжээ⁹.

1.62 Түлхүүр гардуулах Олон улсын FIDIC гэрээний нөхцөлийг захиалагч гүйцэтгэгч талууд хэлэлцэж тохиролцсон талаарх баримт байхгүй байна.

1.63 Энэ нь Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.8¹⁰, 189 дүгээр зүйлийн 189.2¹¹, Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасантай тус тус нийцэхгүй байна.

1.64 Иймд төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авалгүйгээр байгуулсан энэхүү гэрээг хүчин төгөлдөр бус хэлцэл гэж үзэхээр байна.

1.65 төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч хэрэгжилтийн шатанд уг төслийг нийслэлийн төсвийн хөрөнгөөр түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ байгуулан хэрэгжүүлж эхэлсэн нь бодлого, шийдвэрийн уялдаа, залгамж чанарыг алдагдуулж байна.

1.66 Төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр баталсан шийдвэр хүчин төгөлдөр хэвээр байгаа тохиолдолд хуульд нийцүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар аудитын баг зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

“Туулын хурдны зам” төслийн төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлтэй байгаагаас гадна төслийг үргэлжлүүлэх эсэх нь тодорхойгүй байна

1.67 Төслийн захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч НЗХГ-аас 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 04/890 тоот албан бичгээр авто зам, замын барилгын ажлын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил 40 хоног, Түр барилга, байгууламж ба барилгын ажил 99 хоног хоцорсон тухай гүйцэтгэгч байгууллагад хүргүүлж байжээ.

1.68 Харин Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар уг төслийг зогсоож нийт 128 хоногийн хоцрогдолтой байна.

1.69 Иймээс гэрээний ерөнхий хэлцлийн дагуу дараах нөхцөл байдал үүсээд байна.

Захиалагч талаас

а/ Хийж гүйцэтгэсэн аливаа ажлын Гэрээнд заасан дүнгээр тооцсон төлбөл зохих дүн;

б/ Гэрээ цуцалсан өдөр хүртэл ажилтай холбогдуулан хөлслөн ажиллуулж байсан Гүйцэтгэгчийн ажилчдыг бүгдийг нь эх оронд нь буцаахтай холбоотой зардал

с/ Гэрээг цуцалснаас үүдэн Гүйцэтгэгчид учирсан аливаа ашгийн алдагдал, эсхүл бусад алдагдал болон хохирлын хэмжээг Гүйцэтгэгчид төлж барагдуулна.

Гүйцэтгэгч талаас

Түр зогсолтыг хугацаа 84 хоногоос хэтэрсэн бол Гүйцэтгэгч гэрээ цуцлах мэдэгдэл хүргүүлж гарсан зардлыг харилцан тохиролцож болно.

Харилцан тохиролцоонд хүрч чадаагүй болон түр зогсолт нь төсөлд бүхэлд нь нөлөөлсөн бол гэрээ цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.

а/ Хийж гүйцэтгэсэн аливаа ажлын Гэрээнд заасан дүнгээр тооцсон төлбөл зохих дүн;

б/ Гэрээг цуцалснаас үүдэн Гүйцэтгэгчид учирсан аливаа ашгийн алдагдал, эсхүл бусад алдагдал болон хохирлын хэмжээг Гүйцэтгэгчид төлж барагдуулна.

1.70 Гэрээний 2.4-т "Хэрэв захиалагч нь Санхүүжилтдээ томоохон хэмжээний өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн эсхүл түүний санхүүгийн нөхцөл байдалд өөрчлөлт орсны улмаас Санхүүжилтээ өөрчлөх/Захиалагчаас тогтоосон хугацаанд төлөх ёстой үлдэгдэл төлбөрийг төлөх Захиалагчийн чадавхад нөлөөлөхөөр/ болсон бол дэлгэрэнгүй мэдээлэл бүхий мэдэгдлийг Гүйцэтгэгчид нэн даруй хүргүүлнэ. Хэрэв гүйцэтгэгч нь:

9 11.1.5-д "энэ хуулийн 13.2-т заасан түншлэлээр хэрэгжүүлэх төслийн түншлэлийн гэрээ байгуулах эрхийг аймаг, нийслэлийн Засаг даргад олгох"

¹⁰ хуулиар тогтоосон хэлбэрийг зөрчсөн, хуульд заасан тохиолдолд зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хэлцэл;

¹¹ Нийгэм, хувь хүний ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор зарим төрлийн гэрээг гагцхүү төрийн эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр байгуулж болно. Зөвшөөрөл олгох журмыг хуулиар тогтооно"

а/ гэрээний хэлэлцээрт заасан Гэрээний үнийн дүнгийн 10% илүү үнийн дүн бүхий ажилд өөрчлөлт хийх зааварчилгаа авсан эсхүл нийт ажлын өөрчлөлтүүд нь Гэрээний үнийн дүнгийн 30 хувиас хэтэрсэн тохиолдолд

б/ 14.7 заасан төлбөрийг хүлээн аваагүй бол

с/ Захиалагчаас санхүүжилтдээ томоохон хэмжээний өөрчлөлт хийсэн тухай Мэдэгдлийг Гүйцэтгэгчид энэхүү хэсэгт заасны дагуу хүлээн аваагүй бол гэж заасан байна. Энэ нь тендерийн баримт бичиг, өгөгдлийн хүснэгт, тендер шалгаруулалтын зааварчилгаанд заасантай нийцээгүй байна.

1.71 БХТ-ийн 2025 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн 316/2025 дугаартай Магадлалын ерөнхий дүгнэлтийн нэгтгэлд тухайн төслийн нийт шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ нь хот байгуулалтын баримт бичигтэй уялдуулан ажлын зургийн шатанд өөрчлөгдөж, нарийвчлан тооцох шаардлагатайгаар тусгасан байгаа нь төсөвт өртөг өөрчлөгдөх боломжтой гэдгийг дурдсан байна.

Төслийг төлөвлөж хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжид бүрэн нийцүүлээгүй байна

1.72 Хот, тосгоны ирээдүйн хөгжил, эдийн засаг, нийгэм, дэд бүтцийн зөв зохистой үйлчилгээг бий болгохын тулд газар ашиглалт, барилгажилт болон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хууль тогтоомжийн уялдаа холбоог хангаж ажиллах шаардлагатай байна.

1.73 Усны тухай хууль, Барилгын тухай хууль, Авто замын тухай хуульд заасны дагуу Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А-230/127 дугаар хамтарсан тушаалаар "Усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам"-ыг баталсан байна.

1.74 Энэ нь Усны тухай хуулийн өөрчлөлтөөс өмнө зам гүүрийг онцгой хамгаалалтын бүсэд барьж болохоор тусгасан нь хуулиас давсан хэм хэмжээний акт байжээ.

1.75 Гэтэл Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1¹²-д 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн "Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай" хуулиар "бүсэд" гэсний дараа "...Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8-д зааснаас бусад..." гэж нэмэлт оруулсан байна.

1.76 Дээрх зохицуулалтаас үзэхэд "Усны тухай хууль"-д оруулсан нэмэлт өөрчлөлтөөр усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол, мөрний татамд тогтоосон онцгой хамгаалалтын бүсэд барилга, байгууламж барихыг хориглосон байсныг өөрчилж нийтэд зориулсан төрийн үйлчилгээний барилга байгууламж, авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын дээр, доор байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийг барих боломжийг бүрдүүлсэн байна.

1.77 "Усны тухай хууль"-д 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр оруулсан нэмэлт өөрчлөлттэй холбоотой хуулийн төсөл, үзэл баримтлал, хуулийн төсөлд холбогдох байгууллагаас санал авсан эсэх нь тодорхойгүй, шалгадагч болон аудитад хамрагдагч нараас нотлох зүйл ирүүлээгүй болно.

1.78 Дээрх хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар нарийвчлан судалж дүгнэлт гаргах боломж хязгаардагдсан бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн хууль тогтоох бүрэн эрхийн хүрээнд дахин авч хэлэлцэх шаардлага үүссэн байна.

1.79 ТЭЗҮ зураг төсөв, төслийн тухай нэгдсэн ойлголтоггүй байгаа нь томоохон төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хуульд хөрөнгө оруулалтын төсөвт техник эдийн засгийн үндэслэл, хийгдсэн зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон арга хэмжээг тусгана гэж заасан бол ТЭЗҮ-ийн талаар Барилгын тухай хууль,

¹²22.2.1.онцгой хамгаалалтын бүсэд барилга, байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зээс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түгж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно,

Усны тухай хууль, Авто замын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль зэрэг салбарын ангиллаар өөр өөр нөхцөлийг бүрдүүлэхээр байна.

1.80 Өөрөөр хэлбэл Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, төслийн тухай нэгдсэн ойлголтгүй зөвхөн Төсвийн тухай хуульд заасан шалгуурыг хангахын тулд хийгдэж байгаа нэр төдий баримт бичиг болж байна.

1.81 Захиргааны ерөнхий хуулийн 73 дугаар зүйлийн 73.1¹³-т захиргааны байгууллага дараах салбаруудад иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах төлөвлөгөөг боловсруулахдаа олон нийтэд мэдэгдэх талаарх зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:

- хот байгуулалт болон газар зохион байгуулалт хийх;
- олон улсын, улсын, орон нутгийн чанартай авто зам барих, засварлах;
- усны барилга байгууламж, усан цахилгаан станц барих;
- хог, хаягдлын цэгийг байгуулах, өөрчлөх, нүүлгэх;
- зам, талбай, гудамж, усан сан зэрэг нийтийн эзэмшлийн байгууламж, цогцолборыг байгуулах, өөрчлөх, нүүлгэх, буулгах;

1.82 “Туулын хурдны зам” төслийг олон нийтэд танилцуулж санал авсан гэх боловч газар чөлөөлөлт 49.11 хувьтай, буюу бүрэн хийж дуусаагүй, төсвийн төлөвлөлтийн шаардлага хангуулаагүй, ТЭЗҮ, гэрээ байгуулсан зэрэг асуудлыг хангалттай танилцуулаагүй гэж үзэхээр байна.

1.83 Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 73, 74 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 29¹.2.1, 29¹.2.6, Усны тухай хууль, Барилгын тухай хуулийн холбогдох заалттай тус тус нийцэхгүй байх бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нийтийн мэдээллийн үйл ажиллагаанд баримтлах зарчим алдагдсан байна.

1.84 Харин Хот байгуулалтын тухай хуульд хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь тухайн хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу боловсруулсан зураг төслийг хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг тооцож, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тодорхойлох зэрэг цогцоор нь шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

“Туулын хурдны зам”-ын солбицлын цэгийг дахин тооцож шийдвэрлэх шаардлагатай байна

1.85 Зам тээврийн хөгжлийн төвийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 06/2025 дугаартай Магадлалын ерөнхий дүгнэлтийн хавсралт-1 ийн 3-т “9.9.3-т Авто зам, замын байгууламжийн чиглэл байршил төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт хэсэгт: Авто замын чиглэлийг улс, нийслэлийн олон байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр сонгосон, Хурдны замын трасс нь Туул голын татам хэсэгт, зарим хэсэгт голын голдирол дагуулан төлөвлөсөн байна” гэж дүгнэсэн байна.

1.86 “Туулын хурдны зам”-ын трассыг баталсан Засгийн газрын 2013 оны 307 дугаар тогтоолд хуулийн үндэслэлийг тодорхой заагаагүй, 2025 оны 173 дугаар тогтоолд Авто замын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3¹⁴-т заасныг үндэслэсэн бөгөөд тогтоолуудад замын трасс болон солбицол батлах эрх олгосон заалт тусгагдаагүй байна.

1.87 Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2¹⁵-т зааснаар /трасс/-ыг батлах эрх бүхий этгээд тодорхойгүй, Авто замын трассыг батлах талаар холбогдох хуульд нарийвчлан тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

1.88 ЗГ-ын 2013 оны “Хурдны зам баригдах талбайн солбицол батлах тухай” 307 дугаар тогтоолоор баталсан трасст 41 нэгж талбар өртсөн бол НГЗБА-аас ирүүлсэн

¹³ Төлөвлөлт гэж захиргааны байгууллага дараах асуудлаар иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах төлөвлөгөө боловсруулах, түүнтэй холбогдон энэ хуульд заасны дагуу сонсох ажиллагааг явуулж, саналыг хянан үзэж батлах ажиллагааг ойлгоно:


¹⁴ авто замын үндэсний сүлжээг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх

¹⁵ “Захиалагч нь авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, саадгүй хэрэгжүүлэхэд шаардагдах зураг төсөл, замын чиг /трасс/, геодезийн цэгүүд, газар эзэмшүүлэх зөвшөөрөл зэргийг гүйцэтгэгчид хүлээлгэн өгч, авто замын барилгын ажил явуулах талбайг чөлөөлөх асуудлыг шийдвэрлэсэн байна”

судалгаагаар “Туулын хурдны зам” мега төслийн 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн зөвшилцөн баталсан трасст нийт 112 нэгж талбар өртсөнийг Аудитаар тулган баталгаажууллаа. /2013 оны 307-р тогтоолтой давхцаж буй трассыг хавсралт №1-ээс харна уу/

1.89 Цаг хугацааны хувьд авч үзвэл 2025 оны трасст өртсөн 112 нэгж талбараас 86 нэгж талбар нь дээрх тогтоол батлагдсанаас хойш хугацаанд эзэмшил, ашиглалтад шилжүүлэх шийдвэр гаргуулан авсан бол Засгийн газрын 2013 оны 307 дугаар тогтоол батлагдахаас өмнө эзэмших, ашиглах шийдвэр гаргуулан авсан 26 нэгж талбар байжээ. /Дэлгэрэнгүйг хавсралт №5-аас үзнэ үү/

Зураг № 1. Туулын хурдны замын нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдийн судалгаа, ЗГ-ын 2013.08.23-ны өдрийн 307 дугаар тогтоол



Эх сурвалж: Аудитын баг

1.90 Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журмын 8.1-д “Нийслэлийн газрын алба болон улсын бүртгэлийн байгууллага чөлөөлсөн газар, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг дуусгавар болгох, өөрчлөх шийдвэр гаргаж, холбогдох мэдээллийн санд бүртгэнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүйгээс трассын давхцал үүссэн байна.

1.91 Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2¹⁶-д заасныг үндэслэн НИТХ-ын төлөөлөгчдийн 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн “Нийслэл хотын усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай” 69 дүгээр тогтоолоор “Туул голын онцгой болон энгийн хамгаалалтын бүс”-тэй Туулын хурдны замын трасс дараах байдлаар давхцаж байна.


Хүснэгт №7. “Туулын хурдны зам” төслийн трасс, усны сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцаж байгаа тооцоолол

	Замын трассын талбай (м²)	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс	Давхацсан талбай (м²)	Хувь (%)
1	2543100	Онцгой	1 476 460	58.06
2	2543100	Энгийн	1 835 792	72.19

Эх сурвалж: Аудитын баг

¹⁶ Усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтооно”

Зураг №2. “Туулын хурдны зам” төслийн трасс, усны сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцаж байгаа байдал



Эх сурвалж: Аудитын баг


1.92 Ойн тухай хуулийн 3.1.1¹⁷, 3.1.2¹⁸-д ой бүхий газрын талаар тодорхойлсон байна. Туул голын ойн сангийн зураглал дээр төслийн трассыг давхцуулж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №8. “Туулын хурдны зам” төслийн трасс, ой бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцаж байгаа тооцоолол

№	Замын трассын талбай (м ²)	Ойн сан	Давхацсан талбай (м ²)	Хувь (%)
1	2543100	Ой	447 608	17.60
2	2543100	Тэлэн ургахад шаардлагатай талбай	524 474	20.62

Эх сурвалж: Аудитын баг

Зураг №3. “Туулын хурдны зам” төслийн трасс, ой бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцаж байгаа байдал



Эх сурвалж: Аудитын баг

¹⁷ “ой” гэж мод, бут, сөөг болон бусад ургамал, хаг хөвд, амьтан, бичил биетэн шүтэлцэн орших хам бүрдлийн экологи-газарзүйн онцлог нөхцөл бүхий орчныг”,

¹⁸ ойн сан” гэж энэ хуулийн 3.1.1-д заасан ой, ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй болон ойн тэлэн ургахад шаардлагатай талбай бүхий орчныг”


1.93 Усны тухай хуулийн 22.4¹⁹-д заасны дагуу дагуу Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан А-230/127 тушаалаар баталсан журмын 3.2-д “Усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс нь эрүүл ахуйн хориглолтын ба эрүүл ахуйн хязгаарлалтын бүсээс тогтоно” гэж заасан бөгөөд трассыг давхцуулж үзэхэд дараах нөхцөл байдалтай байна.

Хүснэгт №9. “Туулын хурдны зам” төслийн трасс, эрүүл ахуйн хориглолтын бүхий бүстэй давхцаж байгаа тооцоолол

№	Замын трассын талбай (м²)	Ундны усны эрүүл ахуйн бүс	Давхацсан талбай (м²)	Хувь (%)
1	2543100	Хориглолт	1 790 402.8	70.40
2	2543100	Хязгаарлалт	1 903 796.1	74.86

Эх сурвалж: Аудитын баг

Зураг №4. “Туулын хурдны зам” төслийн трасс, эрүүл ахуйн хориглолтын бүхий бүстэй давхцаж байгаа байдал



Эх сурвалж: Аудитын баг

1.94 НГЗБА-нд 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр НЗХГ-аас ирүүлсэн замын трасст өртөж байгаа 112 нэгж талбарын талаарх мэдээллийг дараах хүснэгтээр харуулж байна. /Доорх хүснэгтийн задаргааг хавсралт №8-аас үзнэ үү/

Хүснэгт №10. Хориглолт, хязгаарлалт, хамгаалалтын бүсэд давхацсан нэгж талбарын тоо /давхардсан тоогоор/

Д/д	Туулын хурдны замын трасст давхацсан нэгж талбарын тоо	Хориглолт, хязгаарлалт, хамгаалалтын бүсэд давхацсан нэгж талбарын тоо							
		Усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс	Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс	Усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүс	Усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хязгаарлалтын бүс	Ойн сан бүхий газар	Ойн тэлэн ургах нөөц газар	Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын бүс /35 кВ/	Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын бүс /110 кВ/
1	112	10	27	33	37	4	11	9	6

Эх сурвалж: Аудитын баг

¹⁹ Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмыг байгаль орчны болон газрын харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах бөгөөд энэ журмаар онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, бүсэд мөрдөх дэглэмийг тогтооно.”

1.95 “Туулын хурдны зам” төслийн трасст өртсөн 112 нэгж талбараас 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 55 нэгж талбарыг чөлөөлсөн бөгөөд дүйцүүлэх буюу талбай шилжүүлэх байдлаар 20 нэгж талбар, нөхөх олговор олгож 35 нэгж талбар чөлөөлж, нөхөх олговорт 8.1 тэрбум төгрөг олгосон байна.

1.96 Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1²⁰-д нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх талаар нарийвчлан тусгасан бөгөөд газар чөлөөлөлтийг хуульд нийцүүлэн бүртгэж, ил тод зохион байгуулаагүйгээс газрын давхцал, маргаан үүсэж, төслийн хэрэгжилтэд саад учруулах, зардал өсөх нөхцөл бүрдсэн байна.

1.97 Харин газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа газрыг чөлөөлөхдөө “Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журам”-ыг мөрдөж ажиллах, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг дуусгавар болгох, цуцлах, хүчингүй болгох нэгж талбар байгаа эсэхийг нягтлан мэдээллийн санд оруулах талаар аудитын баг албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

1.98 Засгийн газраас батлан гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хүчинтэй байдал, залгамж чанараар эрэмбэлж, хуульд нийцүүлэн нягталж шалгах хэрэгцээ шаардлага бий болсон байна.

²⁰ Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төвлөрлийг сааруулах зорилгоор хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Засгийн газрын шийдвэрийн дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн энэ хуулийн 10.7-д заасан журмын дагуу газар чөлөөлнө..


БҮЛЭГ 2. ТӨСЛИЙГ ТӨЛӨВЛӨХ, ЭХЛҮҮЛЭХ, ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧИГ ХУУЛЬ ТОГТООМЖИД БҮРЭН НИЙЦЭЭГҮЙ, БЭЛЭН БАЙДАЛ ХАНГАГДААГҮЙ БАЙНА

Төслийн ТЭЗҮ, зураг төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулаагүй, хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна

2.1 Техник, эдийн засгийн үндэслэл нь ямар нэгэн төсөл, бизнес, хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхээс өмнө боломжтой эсэх, ашигтай эсэхийг бүх талаас нь үнэлж дүгнэдэг судалгаа, тооцоолол бүхий баримт бичиг юм.

2.2 Монгол Улсад ТЭЗҮ-ийн талаар хуульчлагдсан, нэгдсэн нэр томъёоллоор бүрэн тодорхойлогдоогүй боловч хэд хэдэн хууль тогтоомжид шаардлага хэлбэрээр баримт бичгийн бүрдэл төдий хэрэгсэл болж, ач холбогдол нь буурах хандлагатай байна.

Дүрслэл №5. ТЭЗҮ-г салбарын ангиллаар харуулбал



2.3 ТЭЗҮ гэж “Төслийг хэрэгжүүлэх боломж, технологийн шийдэл, байршил, хүчин чадал, хөрөнгө оруулалтын хэмжээ, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, байгаль орчны нөлөөлөл, эрсдэлийг үнэлж тооцсон, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад ашиглагдах иж бүрэн судалгаа, дүн шинжилгээнд суурилсан баримт бичгийг” хэлнэ гэж тодорхойлжээ.

2.4 “Туулын хурдны зам” төслийн тухайд барилга байгууламжийн дэд бүтцийн салбарт хамааруулж үзэн холбогдох шийдвэрүүдийг гаргасан хэдий ч хийц, технологийн онцлогийг харгалзан авто зам, замын байгууламж, хурдны зам, гүүрэн гарц, олон түвшний уулзвар, цахилгаан хангамж, дохиолол холбоо гэх мэт бүрдэл хэсгийг цогцоор нь шийдэх нарийвчилсан зураг төсөл боловсруулан хэсэгчлэн болон үе шаттайгаар магадлал хийлгэснээр хууль тогтоомжийн шаардлагад бүрэн нийцэхээр байна.

Эх сурвалж: Аудитын баг


2.5 Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 27 дугаар тушаалаар Нийслэл Улаанбаатар хотын “Туулын хурдны зам”-ын Техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан зураг төслийн баримт бичигт экспертиз хийх ажлын хэсэг байгуулсан байна.

2.6 Дээрх ажлын хэсэг Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2011 оны 08 дугаар сарын 18-ний өдрийн 226 дугаар тушаалаар баталсан “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм”-ийг баримтлан магадлал хийсэн гэж тайлбарладаг.

2.7 Олон салбарыг хамруулан гүйцэтгэсэн төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төслийг нэгтгэн магадлал хийхэд төсвийн тооцоолол, норм дүрэм, стандартын зөрүүтэй байдлаас алдаа дутагдал үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг байна. Тухайлбал тайлангийн *Хавсралт №2*-т төслийн төсвийн тооцооллыг авто зам болон барилгын норм стандартаар зэрэгцүүлэн харууллаа.

2.8 МУЗГ-ын 2013 оны 307 дугаар тогтоол, НЗД-ын Зам, тээвэр, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч, Улаанбаатар хотын ерөнхий архитектор бөгөөд Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газрын дарга, ЭЗХЯ, “Гудамж” төсөл нэгжийн захирал нарын баталсан зургийн даалгаврын дагуу “Эм Си Пи Си Жи Ар” ХХК “Туулын хурдны зам” мега төслийн нарийвчилсан зураг төсөл, төсвийг боловсруулж нийт 9 удаа МЕД гарсан байна.

Дүрслэл №6. Нарийвчилсан зураг төсөл, төсөвт хийсэн МЕД-ийн үйл явцын зураглал (2014-2024 он)



Эх сурвалж: Аудитын баг

2.9 Төслийн зураг, төсвийг шинэчлэх НЗХГ/2024-A1326-1 дугаартай ажлын гэрээг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр НЗХГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан Гудамж төслийн хүрээнд хийгдсэн ажлын даалгавар²¹-ыг үндэслэн НЗДТГ болон “Эм Си Пи Си Жи Ар” ХХК-ын хооронд 4.2 тэрбум төгрөгөөр байгуулсан байна.

2.10 Гэтэл Зам, тээврийн сайдын 2024 оны А/276 дугаар тушаалаар тус компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр боловсруулсан баримт бичгийг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-т актаар хүлээлгэн өгчээ.

2.11 Төслийн “ТЭЗҮ, урьдчилсан зураг төсөв боловсруулах” зөвлөх үйлчилгээний гэрээг 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр НЗДТГ болон “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын хооронд 100.0 сая төгрөгөөр байгуулсан байна.

2.12 ТЭЗҮ-ийн инженерийн судалгааны тайлан, урьдчилсан зураг төслийг 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр ЗТЯ-ны ШУТЗ-ийн дэргэдэх Авто замын салбар дэд зөвлөлийн хурлаар хэлэлцэж, авто замын түгжрэлийн судалгаа, тооцооллыг дахин нарийвчлах, 2014 оны хуучин ТЭЗҮ-ийн зохиогчийн эрхийг тодруулж холбогдох хууль журамд нийцүүлэх зөвлөмж өгснийг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн ШУТЗ-ийн хурлаар дэмжсэн байна.

2.13 Гэвч ТЭЗҮ-ийн бүрдэл болох “**Нийгмийн судалгааны тайлан**” нь улс төрийн шинжлэх ухааны доктор, профессорын гарын үсгээр баталгаажиж албажаагүй байгаа нь бодит тооцоо судалгаанд суурилсан, үндэслэл бүхий баримт бичиг гэж үзэхээргүй байна.Тухайлбал,

²¹ “Туулын хурдны авто зам, замын байгууламжийн нарийвчилсан зураг төслийг өөрчлөх, шинэчлэн боловсруулах” ЗД-24/25 дугаар

- Улаанбаатар хотын агаарын дундаж хэмийг өвөл -44, зун +37 градусаар, хүн амын тоог зөрүүтэй (1,734,800; 1,640,781; 1,640,800) тусгаасан,
- Тайланд нийт 499 иргэнийг хамруулсан нь бүрэн төлөөлж чадахгүй, төслийн дараах ядуурлыг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх, БЗХӨ/ДОХ болон хүний наймааны эрсдэл нэмэгдэх зэрэг дүгнэлтүүд нь Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл, хүн ам зүй, гэмт хэргийн суурь статистик болон эдийн засгийн нарийвчилсан тооцоо, загварчлалд тулгуурлаагүй, ОУ-ын туршлагыг хуулбарласан ерөнхий тайлбар хэлбэрээр бичигдсэн,
- Монгол Улсын нийгмийн салбарт тулгамдсан асуудлууд болох хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон болон эмзэг бүлгийн өрхүүдэд үзүүлэх нөлөө, боловсрол, эрүүл мэндийн хүртээмж, газар ашиглалт, нүүлгэн шилжүүлэлт, замын аюулгүй байдал, хүйсийн тэгш байдал, түүнчлэн түгжрэл, агаарын бохирдолд нөлөөлөх бодит нөлөөллийг бүрэн орхигдуулж, дүн шинжилгээ хийгээгүй байна.

2.14 **Эдийн засгийн шинжилгээний тайланд** орсон мэдээллээс дурдвал дараах асуудлууд байна. Тухайлбал,

- Суурь тоон мэдээллүүд бодитой бус,
- Улаанбаатар хотын хур тунадас, агаарын температур, хүн ам, хүйсийн харьцаа,
- Тайлангийн 2 дугаар бүлгийн 2.5.2-т өндөр өртөгтэй авто зам барих нь ирээдүйд үр дүн багатай бөгөөд хүлэмжийн хий, осол, шатахууны үнийн өсөлтийг дагуулдаг гэж тайлбарласан нь тухайн төслийн бодлогын зорилгыг үгүйсгэсэн, зөрүүтэй дүгнэсэн,
- Дэлхийн банкны HDM-4 программыг ашиглаагүй, гол таамаглалын өөрчлөлтийг шалгах мэдрэмжийн дүн шинжилгээг ЗТХС-ын 2018 оны 168 дугаар тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам”-ын дагуу хийгээгүй байна.

2.15 Нийгмийн судалгаа болон Эдийн засгийн шинжилгээний тайлангийн ижил нэгж, тоон утга бүхий мэдээллүүд зөрүүтэй тусгагдсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №10. Нийгмийн судалгаа болон Эдийн засгийн шинжилгээний тайлангийн мэдээллийн зөрүү

№	Нийгмийн судалгааны тайлан	Эдийн засгийн шинжилгээний тайлан
1	Жилийн дундаж тунадас уналтын хэмжээ 258.5 мм	Сүүлийн таван жил (2019-2023)-ийн хур тунадасны хамгийн их хэмжээ 127.8 мм бол дундаж нь 27.7 мм
2	Өвлийн цаг агаарын дундаж хэм -44 градус, зун нь дунджаар +37 хэм	Мөн сүүлийн таван жилийн утгаар үнэмлэхүй бага температур -35.5 C ⁰ , үнэмлэхүй их температур +34.5 C ⁰ хэм
3	Улаанбаатар хотын хүн амын тоо 2023 оны байдлаар 1,734,800	793.4 мянган эрэгтэй (48.36%), 847.3 мянган эмэгтэй (51.64%) нийт 1,640,781 хүн буюу 465,059 өрх
4	2020 онд нийт 383,703 байсан бол 2022 онд 435,725, 2023 оны эцсийн байдлаар 473,673 буюу бараг хагас сая автомашинтай болжээ	2023 онд 55,483 болж өсжээ, хүснэгтээр харуулахдаа 2023 онд 555,483, графикаар харуулахдаа 2023 онд 473,673


Эх сурвалж: ТЭЗҮ, Нийгмийн судалгаа болон Эдийн засгийн шинжилгээний тайлан

2.16 Төслийн нийгэм, эдийн засгийн судалгааг нөлөөлөлд өртөгчийн бодит нөхцөл байдлыг тодорхойлох, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах эерэг, сөрөг нөлөөг шинжлэх, үнэлэх, цаашид сөрөг нөлөөлөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газрын 2024 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан журмын²² дагуу зохион байгуулдаг бөгөөд тус журмын 4.2²³-т заасны дагуу мэдээллийг ил тод, нээлттэй танилцуулж, санал аваагүй байна.

²² Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журам

²³ Газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа газрын газар өмчлөгч, эзэмшигч иргэн, хуулийн этгээд, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхтэй этгээд (цаашид “нөлөөлөлд өртөгч” гэх)-д төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг ил тод, нээлттэй танилцуулж, санал авна.

2.17 Төсөл хэрэгжүүлэхэд Байгаль орчны нөлөөллийн талаар дараах 4 төрлийн дүгнэлт, тайланг боловсруулж батлуулдаг байна.



Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ “БОТБУ”-ний тайлангийн талаар

2.18 Дээрх 4 баримт бичгээс ТЭЗҮ-ийн бүрдэл болох БОТБУ-ний тайлан²⁴ нь Улс болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлох суурь судалгааны баримт бичиг юм.

2.19 НЗХГ-ын даргын баталсан 2024 оны 24010100177 дугаартай “Төслийн ТЭЗҮ, урьдчилсан зураг, төсөл боловсруулах” ажлын даалгаврын дагуу “Эм Си Пи Си Жи Ар” ХХК болон “Монгазар экологи” ХХК-ийн хооронд 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр БОТБУ-ний тайланг боловсруулах гэрээг 30 хоногийн хугацаатай байгуулсан байна.

Чанартай боловсруулсан БОТБУ-ний тайлан нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн үндсэн суурь баримт бичиг болно.

2.20 Гэвч төслийн суурь судалгааг өвлийн улиралд, 24 хоногийн хугацаанд, хээрийн болон урьдчилсан судалгааны ажил бүрэн хийх боломжгүй нөхцөлд хийсэн, бодит тооцоо судалгаанд үндэслээгүй, БОНХ-ийн сайдын 2014 оны А-117 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”, “Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу боловсруулаагүй байна.

2.21 Ургамал болон усны чиглэлээр нарийн мэргэжлийн шинжээч ажиллаагүй, ашигласан материалын эшлэл бүрэн хийгдээгүй, тайлангийн агуулга, бүтэц зохион байгуулалт, утга найруулгад мэргэжлийн бус алдаа ихтэй, тайлангийн бүлгүүд иж бүрэн дүгнэлтгүй зэрэг нь чанарын шаардлага хангасан гэж үзэхээргүй байна.

2.22 БОТБУ-ний тайланг хянаж үзэхэд дараах алдаа, зөрчлүүд байна.Үүнд:

- Туул голын усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн 50 метр зайд хэсэгчлэн давхцалтай газруудыг нарийн зураглаж тооцоогүй;
- БОННУ-ний тайланд тусгагддаг БОМТ-ын зардлын тооцоо, төслийн осол эрсдэлийн үнэлгээг оруулсан;
- Хөрсний судалгаа, шинжилгээний ажлыг холбогдох арга аргачлал, стандартын дагуу хийгээгүй;

²⁴БОНБУ-ний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т “байгаль орчны төлөв байдлын үнэлгээ” гэж аливаа төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг” хэлнэ

- **Ургамал нөмрөгийн** судалгааг өвлийн улиралд хийсэн нь үндэслэлгүй /экологийн болон агро-цаг уурын судалгаанд ургамал ургалтын хугацааг хаврын +5°C-аас намрын +5°C-аас хүртэлх хугацаагаар тодорхойлдог/;
- Мэдээллийг Богд хан уулын ДЦГ-аар төлөөлүүлэн хийсэн хэдий ч ашигласан бүтээлийн иш таталт бүрэн хийгдээгүй нь Зохиогчийн эрхийн тухай хууль, Иргэний хууль, Зөрчлийн тухай хуультай тус тус нийцээгүй;
- **Ойн** судалгаанд трассын дагуу өртөж буй ойн сангийн талбайн моддын насыг нарийвчлан тогтоогоогүй нь Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1²⁵, 30 дугаар зүйлийн 30.2²⁶ -т заасантай нийцээгүй, модны экологи-эдийн засгийн үнэлгээг төслийн талбайд 54.23 га талбай өртөхөөр 1,001.51 сая төгрөгөөр тооцсон нь бодитой бус;
- Трассын дагуу өртөх ойн сангийн талбайд нарийвчилсан судалгаа хийж, шилжүүлэн суулгах боломжтой өсвөр болон залуу моддын төрөл зүйл, тоо хэмжээ, байршлыг тогтоогоогүй, ойн тэмдэглэгээнд заган ойг оруулсан нь бодитой бус;
- **Усан орчны** судалгаанд материалын эшлэл дутуу, эх сурвалжгүйгээр бичсэн, эшлэл хийсэн материалд дүн шинжилгээ хийгээгүй;
- 2014 онд хийгдсэн Туул голын ус зүйн тооцоог шууд ашигласан, өөрсдийн тодорхойлсон шинжилгээний үр дүнтэй харьцуулалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй;
- Усны шинжилгээнд хүнд металлын болон нефтийн бүтээгдэхүүний шинжилгээ хийгээгүй;
- Туул голын усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн шинж чанар, нөлөөллийн хэлбэр, эрчмийг дутуу, тодорхой бус ойлгомжгүй үнэлсэн;
- Гадаргын усны бүлэгт судалгаа хийсэн арга зүй тусгаагдаагүй, трассын дагуу усны дээж авахдаа хэт цөөхөн цэгээс авсан, нөлөөллийн үнэлгээний хүснэгт тайлбар дутуу, давхардсан агуулгатай, газрын доорх усны чанарын судалгааг хангалтгүй хийсэн.

2.23 Түүнчлэн ТЭЗҮ-ийн бүрдэл суурь судалгаа болох төслийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгааны тайланг захиалагч болон гүйцэтгэгч талууд олон нийтэд нээлттэй байршуулаагүй нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1²⁷ дэх хэсэгт заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2.24 ТЭЗҮ-ийн бүрдэл суурь судалгаа болох төслийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгааны тайланг бодит тооцоо судалгаанд үндэслэн, холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, олон нийтэд нээлттэй байршуулаагүй нь иргэд үнэн зөв, бодит мэдээллээр хангагдах боломжгүй болгосон байна.

2.25 Иймд төслийн ТЭЗҮ-ийн бүрдэл дэх нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгааны тайланг бодит тооцоо судалгаанд үндэслэн, холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулахад тавих хяналтыг сайжруулах, олон нийтэд нээлттэй танилцуулж хэвших нь зүйтэй байна.

Төслийн ТЭЗҮ, урьдчилсан зураг төсөл, төсөвт магадлал хийсэн нь хууль тогтоомжид нийцээгүй, чиг үүргийн давхардал, ойлгомжгүй нөхцөл байдлыг бий болгожээ

2.26 ЗТХТ ТӨҮГ нь 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05/2025 дугаартай МЕД-ээр ТЭЗҮ-ийн бүрдэл, урьдчилсан зураг төсөл, БХТ ТӨҮГ нь 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 316/2025 дугаартай МЕД-ийг гаргасан байна.

²⁵“насны тавдугаар анги хүртэлх ой, бүх төрлийн өсвөр модыг огтлох, хугалах, гэмтээхийг хориглоно”

²⁶ “иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага огтолсон нэг модны оронд арав буюу түүнээс дээш тарьц, суулгацыг ойд тарьж ургуулан, улсын ойн санд хүлээлгэн өгнө”

²⁷ 8.1-д Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.

Д.д	Байгууллага	Огноо	Дугаар	Объектын хүчин чадал	Ажлын даалгавар	Төсөв
1	ЗТХТ ТӨҮГ	2025.01.23	06/2025	ТЭЗҮ-ийн инженерийн судалгааны тайлан /урьдчилсан зураг төсөл/	НЗХГ-ын 2024 онд баталсан ЗД-24/25 дугаар	-
2	БХТ ТӨҮГ	2025.03.18	316/2025	ТЭЗҮ, урьдчилсан зураг төсөв	НЗХГ-ын 24010100177 дугаартай ажлын даалгавар, НЗХГ-ын 2024 онд баталсан ЗД-24/25 дугаар	2,384.0

Эх сурвалж: Магадлалын ерөнхий дүгнэлт

2.27 МЕД-ийг гаргахдаа “Нийгмийн судалгааны тайлан”, “Эдийн засгийн шинжилгээний тайлан”, БОТБҮ-ний тайланг ЗТХ-ийн сайдын 2018 оны 168 дугаар тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам”-ын 4.1.2²⁸, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тушаалаар баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 6.11.1²⁹-д заасны дагуу хянаж хүлээж аваагүй байна.

2.28 Дээрх магадлагдсан ТЭЗҮ-д “Урьдчилсан зураг төсөл”, “Урьдчилсан зураг төсөв” гэж тусгасан байна. Гэвч “Авто замын тухай хууль”, “Барилгын тухай хууль”, “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль”, “Төмөр замын тээврийн тухай хууль”, “Эрчим хүчний тухай хууль”, “Төсвийн тухай хууль” зэрэг холбогдох хууль тогтоомжид “урьдчилсан зураг төсөл” гэсэн нэр томъёо байхгүй байна.

2.29 ТЭЗҮ, урьдчилсан зураг төсөл, төсөвт магадлал хийсэн нь хууль тогтоомжид нийцээгүй, ойлгомжгүй нөхцөл байдлыг бий болгож, салбар хоорондын уялдаа холбоо хангагдаагүй, төслийн нарийвчилсан тоо хэмжээ зөрөх, төсөвт өртөгт өөрчлөлт орох, хяналт, хариуцлагын тогтолцоог алдагдуулах нөхцөл байдлыг үүсгэсэн байна.

2.30 Энэ нь “Авто замын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.18³⁰, “Барилгын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.30³¹-д, ЗТХС-ын 2018 оны 168 дугаар тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам”-ын 9.1³² -д заасантай нийцэхгүй, техникийн зураг төсөлд хамруулан ойлгож болох тухай тайлбарласан нь үндэслэлгүй байх тул аудитын баг албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

2.31 Цаашид хот төлөвлөлтийн талаар төсөл арга хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоог ханган, ойлгомжтой хуульд нийцсэн, цогц бодлого шийдвэрийн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

²⁸ 4.1.2. эдийн засгийн судалгаа Эдийн засгийн судалгааны ажлыг “Авто зам төсөллөх” нормын 3 дугаар хавсралтад заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

²⁹ 6.11.1. хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангасан эсэхийг хянаж, шалгах;

³⁰ “зураг төсөл” гэж авто зам, замын байгууламжийг барих, засварлах, шинэчлэхэд шаардагдах хайгуул, геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, байгаль орчны судалгаа, нарийвчилсан зураг, техникийн шаардлага, өртгийн тооцооны нэгдсэн баримт бичгийг;

³¹ “зураг төсөл” гэж барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг /эскиз/, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг;

³² “Авто зам, замын байгууламжийн инженерийн шугам сүлжээний нарийвчилсан зураг төсөл, барилгын ажлын төсөвт өртгийн тооцоо, инженер-геологийн судалгааны тайланд магадлал хийнэ”.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо хангалтгүй байна

Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ “БОНЕУ”-ний дүгнэлтийн талаар

БОНЕУ-ний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан ТЭЗҮ, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн хавсралтад заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албанд **байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ**”

2.32 Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээгээр Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх **“шаардлагатай”** гэж дүгнэсэн байна.

2.33 Дээрх дүгнэлтээр төслийн онцлог, үр дагавар, голлох сөрөг нөлөөллийг бүрэн тооцоогүй гэж онцгойлон анхаарах зүйлсийг тодорхойлсон байна. Тухайлбал: нийгэмд үүсээд буй гол асуултад хариулт өгөх газар ашиглалт, чөлөөлөлт, гадаргын болон газрын доорх усны хамаарал, биологийн олон янз байдлын судалгаа, хөрс, ургамал, татмын ой зэрэг асуудлыг дэвшүүлэх боломжтой байжээ.

2.34 БОУАӨЯ-ны зүгээс байгаль орчны талаар суурь судалгаа хийх эрх бүхий аж ахуйн нэгжийн гүйцэтгэсэн тайланд чанар, стандартын хяналтыг хангалттай хийгдээгүйгээс дараагийн шатны дүгнэлт, тайлангийн чанарт сөргөөр нөлөөлж байна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ “БОННУ”-ний тайлангийн талаар

2.35 БОННУ-ний тайланг боловсруулахаар “Тэкол” ХХК болон гүйцэтгэгч “Хаоюань женерал констракшн” ГХО ХХК-ийн хооронд НҮ-НҮМ-НТ-2025-002 дугаартай гэрээг 2025 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр 30 хоногийн хугацаатай байгуулсан байна.

2.36 “Тэкол” ХХК-ийн боловсруулсан БОННУ-ний тайланг баталгаажуулах үйл явцыг доорх зураглалаар харууллаа.

Дүрслэл №7. БОННУ-ний тайланг баталгаажуулах үйл явц



Эх сурвалж: Аудитын баг

2.37 БОННУ-ний тайланг аудитад татан оролцуулсан шинжээчдийн зүгээс хянан үзээд дараах санал шүүмжийг гаргасан байна.Үүнд:

Хүснэгт №13. БОННУ-ний тайланд туссан мэдээллийн шинжилгээний харьцуулалт

	Тэкол ХХК	Аудитаар
ХӨРС	Барилгын бүтээн байгуулалтын ажлын үед “Дунд зэрэг” нөлөөлөлтэй, Авто замын ашиглалтын үед газрын хэвлийд үзүүлэх нөлөөлөл “байхгүй”	Судалгаа тойм байдлаар хийгдсэн, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бүрэн төлөвлөж тодорхойлоогүй
УРГАМАЛ	Барилгын бүтээн байгуулалтын ажлын үед “Их” нөлөөлөлтэй, Авто замын ашиглалтын үед газрын гадарга ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл “байхгүй”	Судалгааны мэдээлэл, зүйлийн бүрдэл, нөлөөллийн үнэлгээ болон нөхөн сэргээлтийн зөвлөмжүүд бодит экосистемийн нөхцөлтэй бүрэн нийцээгүй
ОЙ	Барилгын бүтээн байгуулалтын ажлын үед “Их” нөлөөлөлтэй, Авто замын ашиглалтын үед ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл “байхгүй”	Ойн нөөц, ойн төлөв байдлын мэдээллийг бүрэн тусгаагүй, экологи-эдийн засгийн үнэлгээг бодитой тооцоогүй.

УС	Барилгын бүтээн байгуулалтын ажлын үед “Дунд зэрэг” нөлөөлөлтэй, Авто замын ашиглалтын үед ямар нэг байдлаар усан орчинд бохирдол болон гадаргын усанд үзүүлэх нөлөөлөл “бага”	Гадаргын болон газрын доорх усанд хэрхэн нөлөөлөх талаар тооцоо, загварчлал хийгдээгүй, усны нөөц, горим, чанарыг нарийвчлан үнэлээгүй, ус хангамжийн эх үүсвэрт нөлөөлөх, усны урсцын өөрчлөлт, газрын доорх усны түвшин, зам барилгын үеийн түр усны зохицуулалтыг авч үзээгүй
АГААР	Барилгын бүтээн байгуулалтын ажлын үед “Дунд” нөлөөлөлтэй, Авто замын ашиглалтын үед нөлөөлөл “бага”	
Ерөнхий дүгнэлт	Нийт нөлөөллийн эрчим “Дунд”	Аргачлал, журмын дагуу боловсруулаагүй, шаардлага хангаагүй, сайжруулах, дахин тодотгол хийх

Эх сурвалж: Аудитын баг, БОННУ-ний тайлан

2.38 Гэтэл тус тайланд хууль, эрх зүйн товч тайлбар, дүгнэлт өгөөгүй, тайлангийн агуулга, бүтэц, зохион байгуулалт, алдаатай, ашигласан материалын эшлэл бүрэн хийгдээгүй, мэргэжлийн түвшинд боловсруулаагүй байна.

2.39 БОННУ-ний дүгнэлтээр өгсөн онцгойлон анхаарах асуудлаас Усны тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухайн хуульд нийцэж буй эсэх талаар тайланд иж бүрэн тодорхой тусгаагүй, БОНХ-ийн сайдын 2014 оны А-117 дугаар тушаалаар баталсан "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал", "Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу тайланг иж бүрэн боловсруулаагүй, Мэргэжлийн зөвлөлөөр³³ өгсөн шүүмжийн дагуу засвар иж бүрэн хийгдээгүй, шаардлага хангаагүй тайланг хүлээн авч баталгаажуулсан байна.

2.40 Энэ нь БОНБУТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.4³⁴, 16 дугаар зүйлийн 16.1.1³⁵, 16.1.2³⁶, Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам"-д Мэргэжлийн зөвлөлийн гаргах шийдвэрийн зохицуулалтыг тусгасан бөгөөд 3.4.1³⁷, 3.4.2³⁸-т заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

2.41 БОННУ-ний тайланд дараах алдаа, зөрчлүүд илэрсэн байна.Үүнд:

- Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, Туул голын их үерийн судалгааг нарийвчлаагүй;
- Нүүлгэн шилжүүлэх, нөхөх олговор олгох зардал, төлөвлөгөөг БОМТ-нд тусгаагүй,
- Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөнд зардал тусгаагүй,
- Байгаль орчныг хамгаалах зардлыг 1,512.3 сая төгрөг буюу бодит бусаар /5 жил, хэт бага/ тооцсон;
- Төслийн нөлөөлөлд өртөх талбайн хэмжээг нарийвчлан тодорхойлоогүй нь экологи-эдийн засгийн үнэлгээ бодит бусаар тооцогдох эрсдэл үүссэн;
- Хөрсөн бүрхэвчийн хээрийн судалгааны арга, аргачлалыг буруу ашигласан, төсөл хэрэгжих хугацаанд хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг БОМТ-д багаар тусгасан, зардлыг бодит бусаар тооцсон /нийт 5 арга хэмжээнд 14.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн/;
- Ургамлын судалгаанд ашигласан арга зүй, ургамлын мэдээллийн эх сурвалж тодорхойгүй, суурь мэдээллийн ил тод байдал хангалтгүй;
- Ойн төлөв байдалд моддын дундаж нас, насны анги, өтгөрөл, бонитет (ойн ургах орчин)-ийн анги, моддын ишний эзлэхүүн, ойн нөөц гэх мэт зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүдийг тусгаагүй, зөвхөн дундаж өндөр, диаметр болон ойн бүрэлдэхүүнийг тодорхойлсон нь ойн сангийн экологийн болон эдийн засгийн үнэлгээ бодит бусаар тооцогдох эрсдэл үүссэн;

³³ БОННУ-ний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний асуудлыг зохицуулах, ...үнэлгээний үр дүн, тайланд дүгнэлт өгөх, үүрэг бүхий байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөл ажиллана.

³⁴ “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт...үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ”,

³⁵ 16 дугаар зүйл.БОННУ хийх эрх бүхий аж ахуйн нэгжийн үүрэгт “урьд хийгдсэн шинжилгээ, судалгааны дүгнэлтийг ашиглаж болох бөгөөд түүнийг тодотгох холбогдох чиглэлээр нэмэлт судалгаа хийх;

³⁶ байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд хийсэн шүүмжийн дүгнэлтийн дагуу нэмэлт, өөрчлөлт оруулах;

³⁷ “зарим шаардлагатай засвар, нэмэлт тодруулгыг тусгаж үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлах”

³⁸ “байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал бодит бус, нэмэлт судалгаа, мэдээлэл шаардлагатай гэж үзсэн тохиолдолд батлахаас татгалзаж буцаах”

- **Усан орчин** Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” болон ОУ-ын санхүүжүүлэгч байгууллагуудын нийтлэг шаардлагад төслийг хэрэгжүүлэх альтернатив хувилбаруудыг тооцож үзэхээр заасан боловч нэг хувилбарыг авч үзсэн нь хангалтгүй;
- Гадаргын болон газрын доорх усны чиглэлийн мэргэжилтэн, шинжээч оролцсон эсэх, үнэлгээг ямар мэргэжлийн баг гүйцэтгэсэн талаар тодорхой мэдээлэл тусгаадаагүй нь усан орчны эрсдэл, нөлөөллийг дутуу тооцох эрсдэл үүссэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №3-аас үзнэ үү/

2.42 БОНБУ-ний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3³⁹, Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчны үнэлгээний журам”-ын 7.3.1⁴⁰-д заасны дагуу эрх бүхий аж ахуй нэгжийн үүрэг хариуцлагыг зохицуулсан байна.

2.43 Харин АТГ-ын дарга, тэргүүн комиссарын 2025 оны 01/8713 дугаартай албан бичгийг үндэслэн “Мэргэжлийн зөвлөлийн ажиллах дүрэм”⁴¹-ийг БОУАӨС-ын 2025 оны А/642 дугаартай тушаалаар хүчингүй болгосон нь тайлангийн чанар, үр дүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог тодорхойгүй болгосон байна.

2.44 Иймд мэргэжлийн зөвлөлийн ажиллах дүрэм, шинжээчийн үүрэг хариуцлагыг тодорхой болгож, тайлангийн чанар, үр дүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй байна.

2.45 Мөн БОННУ-ний тайлан нь ТЭЗҮ буюу урьдчилсан зургийн шатанд хангалтгүй хийгдсэн тул БОНБУ-ний тухай хуульд заасны дагуу хянан магадлагаа⁴² хийж, нарийвчилсан зургийн шатанд журмын дагуу дахин тодотгол⁴³ хийх нь зүйтэй талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө “БОМТ”-ний талаар

БОНБУ-ний тухай хуулийн 9.1-д “Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор **Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг** БОННУ-г гүйцэтгэсэн байгууллага боловсруулна.”, 9.2-д “**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь БОННУ-ний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.**”

Төсөл эхлүүлэхэд шаардлагатай хуульд заасан бусад зөвшөөрлийг олгоогүй, дүгнэлт, тайлан гараагүй байхад ажил эхлүүлсэн байна

2.46 Гүйцэтгэгч “Хаоюань женерал констракшн” ГХО ХХК болон “Сайхан ариун дэлхий” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу БОМТ⁴⁴-г боловсруулж, байгаль орчны нөхөн сэргээх баталгааны дансанд 20.05 сая төгрөгийг байршуулснаар БОУАӨЯ 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр баталгаажуулсан байна.

2.47 Гэтэл ЗТХТ ТӨҮГ-ын 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдөр 80/2026 дугаартай МЭД-ээр баталгаажуулсан 5.1 км замын нарийвчилсан зураг төслийг үндэслэн НЗХГ 2026 оны 03 дугаар сарын 15-ны өдөр АЭЗ/ЗБ-25/29 дугаартай “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл”-ийг олгожээ.

³⁹ “байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгийн үнэн зөвийг хариуцах,

⁴⁰ “байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн үр дүнгийн үнэн зөв эсэхийг бүрэн хариуцах”,

⁴¹ БОУАӨС-ын 2025 оны 2 дугаар сарын 28-ний өдрийн А/102 дугаар тушаал

⁴² БОНБУ-ний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгээсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулж байгаа болон учруулсан бол үнэлгээний үнэн зөв хийгдсэн эсэхэд хянан магадлагаа хийнэ”;

⁴³ “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 2.3.9-д “Хэрэгжиж байгаа төслийн ТЭЗҮ, зураг төсөл шинэчлэгдэх, ...хүчин чадал, газрын байрлал өөрчлөх болон байгаль орчны аудитын зөвлөмжөөр нэмэлт тодотгол хийлгээх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийнэ”;

⁴⁴ БОНБУ-ний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага боловсруулна.”; 9.2-д “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.”

2.48 Түүнчлэн авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгохоос өмнө төслийн талбайд археологи, палеонтологи, түүх угсаатны зүйн хайгуулын тандалт, судалгааны ажил хийгдэж эхлээгүй, дүгнэлт тайлан гараагүй байжээ.

2.49 Энэ нь Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3⁴⁵, Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4⁴⁶, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8⁴⁷, БОНБУТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.3⁴⁸ заасантай тус тус нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.50 Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах зөвшөөрлөөс Засгийн газраас олгох 7, тухайн орон нутаг болон ААНБ-аас олгох болон зөвшилцөж 8 зөвшөөрөл авахаас 2026 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 11-ийг авсан бол дараах 4 зөвшөөрөл олгогдоогүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 7-оос үзнэ үү/



2.51 НГЗБА, НЗХГ-ын 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр замын трассыг харилцан зөвшилцсөнөөр НГЗБА-аас төслийн нөлөөлөлд өртсөн чөлөөлөх шаардлагатай 112 нэгж талбарын 100.7 га газрыг чөлөөлөхөөр шийдвэрлэж, ажил эхэлсэн байна.

2.52 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар газар эзэмшигч нарт мэдэгдэл хүргүүлж, газрын үнэлгээ хийж, иргэдтэй зөвшилцөх үйл ажиллагааны үр дүнд 55 нэгж талбарын 76.33 га талбайг чөлөөлсөн ба ажлын явц 49.1 хувьтай буюу хангалтгүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №6-аас үзнэ үү/

Хүснэгт №14. Төслийн газар чөлөөлөлтийн байдал /2026.06.09-ны байдлаар/

Трасст өртсөн нэгж талбар			Газар чөлөөлсөн байдал				
Дүүрэг	Нэгж талбарын тоо	Өртсөн талбай /га/	Нэгж талбарын тоо	Өртсөн талбай /га/	Байршил шилжүүлэх	Нөхөх олговор	Хувь
СХД	87	21.7	44	10.27	25	19	50.6%
БГД	3	12.5	2	12.48	1	1	66.7%
БЗД	8	52.1	6	50.38	6		75.0%
ХУД	14	14.3	3	3.20	3		21.4%
Нийт	112	100.6	55	76.33	35	20	49.1%

Эх сурвалж: Аудитын баг

⁴⁵ “Авто зам, замын байгууламжийг барих зорилгоор газар, түүний хэвлийг хөндөхөөс өмнө палеонтологи, археологи, угсаатны зүйн мэргэжлийн байгууллагаар урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна”, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8-д “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, ...газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна”

⁴⁶ “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, ...зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан байна”.

⁴⁷ “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, ...газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна”

⁴⁸ Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгоно”

2.53 Мөн НГЗБА нь нэгж талбар чөлөөлөх ажлын үнэлгээг тогтоож, иргэн ААН-д нөхөх олговор олгохоос гадна нөхөх олговоргүйгээр газар чөлөөлөх, нэгж талбарын байршил шилжүүлэх зэргээр тасст өртсөн нэгж талбарыг чөлөөлөх ажил хийж байгаа ч төслийн замын зураг төсөл, өндөржилт, далангийн налуу, инженерийн шугам сүлжээ, дам нөлөөлөл, барилга угсралтын ажил гүйцэтгэх зайн хэмжээн тооцоолол зэргээс газар чөлөөлөлтийн ажил удааширч байна.

2.54 "Туулын хурдны зам"-ын барилгын ажил гүйцэтгэх ажлын хуваарийн 2.1-д Газар чөлөөлөлтийн ажлыг 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдөр дуусгах, Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29¹.2.1-т заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.55 Засгийн газрын 2013 оны "Хурдны зам баригдах талбайн солбицол батлах тухай" 307 дугаар "...талбайн солбицол хэсэгт шинээр зориулалтын бус газар олголт хийхгүй байх, барилгын ажил эхлүүлэхгүй байх, солбицлын зурваст газар чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх..." тогтоолоор даалгасан боловч Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгээгүй байгаад аудитын баг албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.56 Түгээмэл тархацтай ашигт малтмал эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрөл хүссэн албан тоотыг гүйцэтгэгчээс захиалагчид 6, 2025 онд НЗД-аас АҮЭБЯ-нд 2, НЗХГ-аас ЗТЯ-нд 1, 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр АҮЭБЯ-нд 1 албан бичгийг тус тус хүргүүлжээ.

2.57 Үүний дагуу АҮЭБЯ-наас АМГТГ, Үндэсний Геологийн алба, ГЗБГЗЗЕГ-ууд уруу 5 талбайн байршлын солбицлын давхцалыг шалгуулахаар хандсанаас АМГТГ болон Үндэсний Геологийн албанаас давхцалгүй гэж хариу ирүүлсэн байна.

2.58 Харин ГЗБГЗЗЕГ-аас 1, 2 дугаар талбай давхцалгүй, 3 дугаар талбай бага зэргийн, 4 болон 5 дугаар талбай нь бүрэн давхцалтай, Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор баталсан "Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай журам"-ын шаардлагад нийцээгүй байна гэсэн тайлбарыг ирүүлсэн байна.

2.59 Дээрх ирүүлсэн тайлбарын дагуу НЗХГ-т журамд нийцээгүй талбайг шинэчлэн ирүүлэх талаар мэдэгдсэн боловч өнөөдрийг хүртэл хүсэлт ирүүлээгүй ТТАМ-ын тусгай зөвшөөрөл олгох асуудал шийдвэрлэгдээгүй, захиалагч, гүйцэтгэгч тал тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

2.60 Мөн Усны тухай хуулийн 30.1.3⁴⁹-д заасны дагуу төслийн кемпийн хаягдал усыг аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ашиглаж байгаа ч мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2⁵⁰-т заасны дагуу холбогдох зөвшөөрлийг аваагүй байна.

2.61 Аудитын тайлангийн төсөлд Усны газраас 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдөр ирүүлсэн албан бичгээр дараах саналыг ирүүлсэн байна. Үүнд:

- "Туулын хурдны зам" төслийн баримт бичгийн бүрдэлд дээрх журмын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг огт тусгаагүй байгааг тэмдэглэх. Усны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу "Усны нөөцийг бохирдох, хомстохоо хамгаалах" нөхцөлийг алдагдуулах тул уг төслийг хэрэгжүүлэх боломжгүй талаар тусгах.
- "Туулын хурдны зам"-ын барилгын ажлын болон ашиглалтад орсон үед гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг тоон загварчлалаар хийгээгүй. Гадаргын усны урсац, чанар, үерийн үеийн асуудал болон газрын доорх усны нөөц, чанарт үзүүлэх нөлөөллийг бодит судалгааны үр дүнд тогтоогоогүй байна,
- Мөн зам ашиглалтад орсны дараах авто машинаас үүсэх бохирдол нь хур тунадсаар дамжин гадаргын болон газрын доорх ус, ялангуяа нийслэлийн ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа гүний худгийн усны чанарт хэрхэн нөлөөлөх судалгаа, тооцоо огт хийгдээгүй байна,

⁴⁹ 30.1.3.хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авах, ашиглалтын явцад гарах бохир усыг хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх, эсхүл шууд зайлуулах;

⁵⁰ "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг хоногт 50 шоо метрээс их ... хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн сав газрын захиргаа,

- “...Нийслэлийн авто замын хөгжлийн газрын хэрэгжүүлэх “Туулын хурдны зам” төслийн ажилчдын ус хангамжид шаардагдах 105.44 м3/хон усыг Туул голоос хангахад хүрэлцээтэй тухай E-2601-000240 дугаартай “Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт”-ийг 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдөр гаргасан...”,
- “...дүгнэлтэд БОННУ-ийн тодотгол болон барилга угсралтын ажлыг эхлэхээс өмнө уг төслийн зам барих ажилд дахин усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулахыг зөвлөсөн..”

2.62 Усны нөөцийн зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд “...устай холбоотой суурь болон нарийвчилсан судалгаа хангалтгүй, холбогдох судалгааны ажлууд бүрэн дуусаагүй, мөн зураг төсөл бүрэн боловсруулагдаж ирүүлээгүй байгаа тул “Туулын хурдны зам” төслийн талаар дүгнэлт гаргах, санал өгөх боломжгүй гэж” шийдвэрлэсэн байна.

2.63 Үүнээс үзэхэд төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, дүгнэлтийг холбогдох эрх бүхий байгууллагаас бүрэн аваагүй эхлүүлсэн нь нийгэмд тодорхойгүй байдлыг бий болгосон байна.

2.64 Иймд Усны тухай 16.4.10⁵¹-д заасан усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын төслийн дүгнэлт, төслийн зам барих ажилд дахин ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг тус тус гаргуулах нь хуульд нийцэхээр байна.

2.65 Түгжрэлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлж байгаа мега төслийн бэлтгэл ажлын хүрээнд шаардлагатай тусгай зөвшөөрөл, дүгнэлт, газар чөлөөлөх зэрэг асуудлыг хуулийн шаардлагад нийцүүлж авах нь зүйтэй байна.

51 16¹.4.10.голын голдирлыг өөрчлөх, урсцад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах, усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд дүгнэлт гаргах;

БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕГА ТӨСЛҮҮДИЙГ ТӨЛӨВЛӨХ, БАТЛАХ, ГҮЙЦЭТГЭХДЭЭ САНХҮҮГИЙН САХИЛГА БАТ, ХАРИУЦЛАГА, ИЛ ТОД БАЙДАЛ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН НИЙЦЛИЙГ ХАНГАЖ ТӨСВИЙН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Нийслэлийн төсвийн орлого тогтвортой өсөж, эерэг үзүүлэлт ажиглагдаж байгаа ч “Туулын хурдны зам” төслийн хувьд төсвийн төлөвлөлт, санхүүжилт хуульд бүрэн нийцээгүй байна

3.1 Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр 2022 оноос дараах байдалтай болсон байна. Үүнд:

- ААНОАТ-ын 40% нь нийслэлд,
- Хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөхийн татвар, газрын төлбөр 100% дүүрэгт төвлөрөхөөр зохицуулагдсан.

3.2 Дээрх өөрчлөлтийн үр дүнд нийслэл, дүүргийн төсвийн орлогын бүтцэд мэдэгдэхүйц томоохон өөрчлөлт орсон байна.

3.3 Нийслэлийн төсвийн орлогын төлөвлөгөөний бүтцийг хотын төсөв, дүүргийн төсвөөр нь авч үзвэл 2022 оноос өмнө нийслэлийн нэгдсэн төсвийн орлогын 70.0 орчим хувийг хотын төсвийн орлого, 30.0 орчим хувийг дүүргийн төсвийн орлого эзэлж байсан байна.

3.4 Дээрх хуулийн өөрчлөлтийг мөрдөж эхэлсэн буюу 2022 оны нийслэлийн нэгдсэн төсвийн орлогын 31.0-39.9 хувийг хотын төсвийн орлого, 60.1-69.0 хувийг дүүргийн төсвийн орлого бүрдүүлж байгааг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт №15. Нийслэлийн 2022-2025 оны Нийслэлийн нэгдсэн төсөв (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2022 он		2023 он		2024 он		2025 он	
	Төсөв	Хувь	Төсөв	Хувь	Төсөв	Хувь	Төсөв	Хувь
Дүүргийн төсөв	1,076.4	67.1	1,521.4	69.0	2,046.1	66.2	2,301.1	60.1
Хотын төсөв	527.2	32.9	683.6	31.0	1,045.1	33.8	1,528.8	39.9
Нийслэлийн нэгдсэн төсөв	1,603.6	100.0	2,205.0	100.0	3,091.1	100.0	3,829.9	100.0

Эх сурвалж. Нийслэлийн 2022-2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Нийслэлийн төсвийн орлогын сүүлийн 4 жилийн гүйцэтгэлийн дунджаар татварын орлого 85.8 хувь, татварын бус орлого 14.2 хувийг тус тус эзэлж, 90.6-110.2 хувийн биелэлттэй, төсвийн нийт орлогын гүйцэтгэл дунджаар 556.6 тэрбум төгрөгөөр өссөн.

Хүснэгт №16. Нийслэлийн 2022-2025 оны төсвийн орлогын гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Он	НИЙТ ОРЛОГО			Үүнээс:					
				ТАТВАРЫН ОРЛОГО			ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
2022	1,699.6	1,603.6	94.4	1,379.7	1,449.9	105.1	319.9	153.7	48.0
2023	2,001.6	2,205.0	110.2	1,769.2	2,011.7	113.7	232.5	193.4	83.2
2024	3,283.7	3,091.1	94.1	2,970.0	2,805.0	94.4	313.8	286.1	91.2
2025	4,222.9	3,826.0	90.6	3,563.9	3,210.6	90.1	658.9	615.3	93.4

Эх сурвалж. Нийслэлийн 2022-2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

3.5 Нийслэлийн 2022–2025 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар төсвийн орлого тогтвортой өсөж, хууль эрх зүйн өөрчлөлтийн үр дүнд орлогын бүтэц шинэчлэгдсэн эерэг үзүүлэлт ажиглагдаж байна.

3.6 Нийслэлийн төсвийн орлогын гүйцэтгэл 2022 онд 1,603.6 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 3,826.0 тэрбум төгрөг болж 2.2 дахин өссөн, орлогын сүүлийн 4 жилийн гүйцэтгэл ХХОАТ, ААНОАТ 73.9 хувийг, хөрөнгийн албан татварын орлого 6.0 хувийг, бусад татварын орлого 9.2 хувийг, татварын бус орлого 10.9 хувийг тус тус бүрдүүлсэн байна.

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Нийслэлийн төсвийн зарлагын гүйцэтгэл 2022 онд 1,417 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 4,526 тэрбум төгрөг болж 3.2 дахин өссөн байна. Зардлын гүйцэтгэл сүүлийн 4 жилийн дунджаар 76.8 хувьтай байгаагаас урсгал зардал 87.9 хувь, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 65.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №17. Нийслэлийн 2022-2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, (тэрбум төгрөг).

Үзүүлэлт	2023 он			2024 он			2025 он		
	Төл.	Гүйц.	Хувь	Төл.	Гүйц.	Хувь	Төл.	Гүйц.	Хувь
Нийт зардал	2,357.7	1,915.9	81.3	4,514.0	3,362.3	74.5	5,834.5	4,526.2	77.6
Урсгал зардал	1,488.8	1,353.8	90.9	1,605.5	1,441.3	89.8	2,297.3	2,075.0	90.3
Хөрөнгийн зардал	829.0	522.2	63.0	2,794.9	1,811.4	64.8	3,482.9	2,396.9	68.8
Зээлийн төлбөр	39.9	39.9	100.0	113.6	109.6	96.5	54.3	54.3	100.0

Эх сурвалж: Нийслэлийн 2022-2025 оны Төсвийн гүйцэтгэлийн тайлан.


3.7 Дээрх зардлын дүнд “Туулын хурдны зам” төслийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 500.0 тэрбум төгрөг төлөвлөн гүйцэтгэлд 401.0 тэрбум төгрөг буюу 80.2 хувь, 2026 онд үлдэгдэл 99.0 тэрбум төгрөгийг олгосон байна.

“Туулын хурдны зам” төслийн төсвийг батлахдаа Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг бүрэн хангуулаагүй байна

3.8 Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/77 дугаар захирамжаар Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Туулын хурдны зам” мега төслийг санхүүжүүлэхийг даалгасан байна.

3.9 Төслийг 2025-2028 онд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар бүрэн санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгасныг хүснэгтээр харуулбал:


Дүрслэл №8. “Туулын хурдны зам”-ын санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгасан байдал, (тэрбум төгрөг)



Эх сурвалж: НИТХ-ын 2025, 2026 оны тогтоолууд, 2027, 2028 оны төсвийн төсөөлөл,

3.10 НИТХ-аар “Туулын хурдны зам” төслийн санхүүжилтийн дүнг дараах тогтоолоор баталсан байна.

Зураг №5. “Туулын хурдны зам” төслийн санхүүжилт баталсан шийдвэр



Эх сурвалж: НИТХ-ын 2024 оны 24/33, 2025 оны 25/50, 25/106, 25/133, 2026 оны 26/05 тогтоол.

3.11 “Туулын хурдны зам” төсөл нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй байна. Үүнд:

- НИТХ-ын 2025 оны 25/50 дугаартай “Нийслэлийн 2025 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолд “Туулын хурдны зам” төслийн төсөвт өртгийг магадлалаар баталгаажсан зураг төсөвгүйдээ 1,964.8 тэрбум төгрөг болгон төсөвт өртгийг 1,048.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- газрын болон шаардлагатай тусгай зөвшөөрлийг бүрэн аваагүй, төслийн дараах урсгал зардлыг урьдчилан тооцоогүй;
- НИТХ-ын 2024 оны 24/33 дугаартай “Нийслэлийн 2025 оны төсөв батлах тухай” тогтоолд “Туулын хурдны зам” төслийн санхүүжих дүнг 538.6 тэрбум төгрөгөөр баталсан боловч НИТХ 2025 оны 25/70 дугаартай “Нийслэлийн 2025 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор санхүүжих дүнг 500.0 тэрбум төгрөг болгон бууруулан нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан;
- НИТХ-ын 2026 оны 26/05 дугаартай “Нийслэлийн 2026 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолд Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр “Туулын хурдны зам” төсөлд 12.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн байна.

3.12 Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁵²-д заасныг хангуулаагүй, мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29¹.2.1⁵³, 29¹.2.2⁵⁴, 29¹.2.4⁵⁵, 29.3.6⁵⁶, Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.8-д “Авто замын сангийн хөрөнгийг энэ хуулийн 24.3, 24.4, 24.5-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

⁵² Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁵³ тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;

⁵⁴ барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

⁵⁵ урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх;

⁵⁶ тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх.

3.13 Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөх, зарцуулах зарчмыг баримталж, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг тооцож, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй байх шаардлагатай байна.

3.14 Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1⁵⁷-д заасан холбогдох хуульд заасны дагуу Нийслэлийн удирдлагын шийдвэр, нийслэлийн төсөв, үйл ажиллагаа ил тод, нээлттэй байж, шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангаж ажиллах үүргээ хэрэгжүүлээгүй нь олон нийтийн хяналтыг сулруулж байна.

“Туулын хурдны зам” төслийн санхүүжилт

Төсөл нь Нийслэлийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөвт өртгийн 49.1 хувь, санхүүжих дүнгийн 29.9 хувийг, 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөвт өртгийн 17.3 хувь, санхүүжих дүнгийн 38.2 хувийг тус тус эзэлж байна

Хүснэгт №18. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 2025, 2026 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ. (тэрбум төгрөг)

Ангилал	2025			2026		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга байгууламж	162	1,784.4	890.9	102	9,472.2	456.6
Тоног төхөөрөмж	23	173.3	127.6	18	70.2	57.4
Их засвар	17	84.6	65.3	12	444.7	423.6
Зураг төсөв	8	174.5	34.7	15	207.8	46.1
Авто замын түгжрэлийг бууруулах	5	2,639.4	549.5	2	3,591.1	1,112.3
НИЙТ	215	4,856.2	1,668.0	149	13,785.9	2,096.0

Эх сурвалж: НИТХ-ын 2025 оны 25/132 дугаар, 2026 оны 26/5 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

3.15 2025 онд төлөвлөсөн санхүүжилтээс төслийн гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөрийн баталгаанд 500.0 тэрбум төгрөгийг олгохдоо гүйцэтгэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө, тоо хэмжээ, ажлын хуваарь зэрэг баримт бичигт үндэслээгүй олгосон байна.

3.16 Энэ нь Сангийн сайдын 2023 оны А/252 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-ын 3.2-д "Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын баримт бичиг болон гэрээнд урьдчилгаа төлбөр олгохоор заасан бол урьдчилгаа төлбөрөөр санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт урьдчилгаа төлбөрөөс багагүй үнийн дүнтэй баталгааг захиалагчид хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

3.17 Төслийг хэрэгжүүлэхэд гэрээний үнийн дүнгээс гадна нийслэлийн төсвөөс 7.8 тэрбум төгрөгийг дараах ажил, үйлчилгээнд зарцуулсан байна.

Хүснэгт №19. “Туулын хурдны зам”-мега төслийн бусад санхүүжилтийн гүйцэтгэл (тэрбум төгрөг)

№	Ажлын нэр	Санхүүжилтийн эх үүсвэр	Дүн
1	Туулын хурдны замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ	Нийслэл	0.1
2	Туулын хурдны замын зураг, төсвийг шинэчлэх ажил	НЗХГ	2.9
3	Газар чөлөөлөх нөхөн төлбөр (2025 он)	Нийслэл	0.8
4	Газар чөлөөлөх нөхөн төлбөр (2026 он)	Нийслэл	3.9
5	“Туулын хурдны зам” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны зардал	Нийслэл	0.05
6	Туулын хурдны зам төслийн гэрээнд зөвлөх үйлчилгээ	НЗХГ	0.03
Нийт дүн			7.8

Эх сурвалж: Аудитын баг

⁵⁷ “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу Нийслэл хотын удирдлагын шийдвэр, нийслэлийн төсөв, үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангана”


3.18 Нийслэлийн нэгдсэн төсвийн төслийг Ulaanbaatar.mn цахим хуудсанд байршуулан иргэдийн саналыг авч нэгтгэн, танхимаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан гэж тайлагнасан бол 2025 онд хэлэлцүүлэгт оролцсон 9 дүүргийн 242 гаруй иргэдээс 207 төсөл, арга хэмжээний саналыг цаасаар хүлээн авсан, 2026 онд хэлэлцүүлэгт оролцсон 9 дүүргийн 350 гаруй иргэдээс 564 төсөл, арга хэмжээний саналыг цаасаар хүлээн авч төсвийн саналд тусгасан байна.

Төслийн төсөвт өртөг 2016 оноос хойш 4 дахин өссөн байна

3.19 Туулын хурдны зам төслийн төсөвт өртөг 4 удаа өөрчлөгдөж, 3 удаагийн өөрчлөлтөд магадлалын ерөнхий дүгнэлт гарсан байна. Үүнд:

- Зам тээврийн хөгжлийн төвөөс 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн магадлалын ерөнхий дүгнэлтээр төслийн нэгдсэн төсөвт өртгийн тооцоог 594.8 тэрбум төгрөгөөр баталгаажуулсан байна.
- Улмаар 2024 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Зам тээврийн хөгжлийн төвөөс нэгдсэн төсөвт өртгийн тооцоог 916.3 тэрбум төгрөгөөр магадлал хийж баталгаажуулжээ.
- Барилгын хөгжлийн төвийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 316/2025 дугаар Магадлалын ерөнхий дүгнэлтээр Хөрөнгө оруулалтын урьдчилсан төсвийг 2.3 их наяд төгрөг, газар чөлөөлөлтөд 170.0 тэрбум төгрөг байхаар тус тус тооцсон бөгөөд 4 дахин өссөн байна.
- Харин доорх дүрслэлд дурдсан 3 дахь удаагийн төсөвт өртөгт магадлалын ерөнхий дүгнэлт хийгдээгүй байна.

Дүрслэл №9. Төсөвт өртгийн өөрчлөлт



Эх сурвалж: Аудитын баг

3.20 Монгол Улсын засгийн газрын гишүүн, зам тээврийн сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын 2025 онд баталсан “Туулын хурдны зам”-ын барилга угсралтын ажлын урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлд барилгын ажлын төсвийг 1,964.8 тэрбум төгрөг, газар чөлөөлөлтөд 170.9 тэрбум төгрөгөөр тусгасан бөгөөд энэхүү төсөвт магадлалын ерөнхий дүгнэлт хийгдээгүй байна.

3.21 Аудитад цугларсан нотлох зүйлд тулгуурлан Монгол Улсын засгийн газрын гишүүн, зам тээврийн сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын “Нийслэл Улаанбаатар хотын зүүнээс баруун чиглэлд хэвтээ тэнхлэгийн “Туулын хурдны зам”-ын барилга угсралтын ажлын урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл батлах тухай” баримт бичигт барилгын ажлын төсвийг 1,964.8 тэрбум төгрөг, газар чөлөөлөлтөд 170.9 тэрбум төгрөг гэж гарын үсэг зурж, тамга дарж баталсан нь Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.4-т заасан үндэслэл үүссэн гэж үзэхээр байна.

3.22 Энэхүү аудитын тайлангийн 1.48 дахь хэсэгт туссан нөхцөл байдал, хамтарсан шийдвэрийн үр дүнгээс харахад гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендэрийн үнийн дүнг тогтоох зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагчдын хамтарсан шийдвэр бүхий баримт бичиг үйлдсэн гэж үзэж холбогдох байгууллагаас тодруулга авахад үндэслэл бүхий тайлбар тодруулга ирүүлээгүй байна.

Хүснэгт №20. “Туулын хурдны зам” төслийн төсөвт өртгийн өөрчлөлтийн мэдээлэл (тэрбум төгрөг)


№	Огноо	МЕД/дугаар	Магадалсан Төсөвт өртөг	Өөрчлөлт	Тайлбар
1	2016.05.18	№067/2016	594.9	-	“Туулын хурдны зам” төслийн анхны батлагдсан төсөвт өртөг, 33 км авто зам, 3,800 у/м гүүр, туннель

2	2024.11.19	№509/2024	916.3	+321.5	Зураг төслийн үндсэн шийдэлд өөрчлөлт ороогүй ч зах зээлийн үнэлгээ болон холбогдох баримт бичгийг үндэслэн төсөвт өртгийг шинэчлэн тооцсон. 33 км авто зам, 3,800 у/м гүүр, туннель
3	-		1,964.8	+1,048.5	ЗГ-ын 2025 оны 01-р сарын 02-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд үндэслэн төслийг 6 эгнээтэйгээр төлөвлөж, ТЭЗҮ/урьдчилсан зураг төслийг дахин шинэчлэн. 32 км авто зам, 6,771 у/м урт гүүр, туннель
4	2025.03.18	№316/2025	2,384.0	+419.2	Трассын дагуух суурьшлын бүсийг дайран өнгөрөх хэсгүүдийн шийдлийг гүүрэн байгууламж болгон өөрчилсөнтэй холбоотойгоор зураг төсөвт дахин өөрчлөлт орж, төсөвт өртөг нэмэгдсэн. 32 км авто зам, 9,878 у/м урт гүүр, туннель

Эх сурвалж: НЗХГ-ын Зам барилгын хяналтын хэлтэс.

3.23 НЗД-ын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/77 дугаартай захирамжаар Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, худалдан авах ажиллагааны эрхийг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн бөгөөд “Туулын хурдны зам” төслийн худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарлан ТШББ-т анхны төсөвт өртөг 1,964.8 тэрбум төгрөг, 2025 онд санхүүжүүлэх дүн нь 538.6 тэрбум төгрөг гэж тусгажээ.

Дүрслэл №10. Төслийн анхны худалдан авах ажиллагааны төсөвт өртөг, холбогдох баримт бичгийн уялдаа, хугацаа



Эх сурвалж: Аудитын баг

3.24 ТЭЗҮ, зураг төсөл, төсөвт магадлал хийхэд салбарын онцлогоос хамааран төслийн нарийвчилсан тоо хэмжээ, төсөв тооцох үзүүлэлт зэрэгт норм дүрэм стандартын зөрүү үүсэж төсөвт өртгийг бодитой үнэн зөв магадласан эсэхэд эргэлзээ үүсэж байна.

3.25 Иймд дээрх асуудлын талаар нарийвчлан судалж бодит нөхцөл байдлыг тогтоож тухайн шийдвэрийн үр дагаварыг тогтоож арга хэмжээ авах нь зүйтэй байна.

“Туулын хурдны зам” төслийн төсөвт өртгийн тооцоолол нь урьдчилсан зураг төсөл, инженерийн төсөөлөл, томсгосон тооцоонд үндэслэсэн бөгөөд нарийвчилсан зургийн шатанд төсөвт өртөгт өөрчлөлт орох нөхцөлийг бий болгосон байна

3.26 ХББОС-ын сайдын 2025 оны “Орон тооны бус экспертүүдийн ажлын хэсэг байгуулах тухай” 27 дугаар тушаалын дагуу ажлын хэсэг төслийн ажлын төсөвт өртгийг хянан БХТ ТӨҮГ нь 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр МЭД гарсан байна.

3.27 МЭД-ээр “Туулын хурдны зам”-ын ТЭЗҮ, урьдчилсан зураг төсвийг 2,384.0 тэрбум төгрөгөөр, газар чөлөөлөлтийн зардлыг 170.0 тэрбум төгрөгөөр тус тус баталсан байна.

Хүснэгт №21. Туулын хурдны замын барилгын ажлын төсөвт өртгийн нэгдсэн товчоон, эзлэх хувь (тэрбум төгрөг)

№	Замын хэсгийн нэр	Бүгд өртөг	Эзлэх хувь
1	Авто зам, Авто замын дагуух үерийн хамгаалалтын далангийн барилгын ажлын төсөвт өртөг	687.07	28.82
2	Төмөр бетон гүүр, туннелийн барилгын ажлын төсөвт өртөг	1,594.47	66.88
3	Авто замын трасст орсон ус хангамж, дулаан хангамж, ариутгах татуургын барилгын ажлын төсөвт өртөг	6.52	0.27
4	Авто замын гэрэлтүүлэг, авто замын трасст орсон ЦШС-г хамгаалах, шилжүүлэх, дэд станц шилжүүлэх, шинээр барих ажлын төсөвт өртөг	28.01	1.17
5	Мэдээлэл холбооны төлөвлөлт /холбооны сувгууд, кабель шилжүүлэх, шинээр барих, RFID систем, камержуулалд, тоног төхөөрөмж, программ хангамж/-ийн ажлын төсөвт өртөг	55.34	2.32
6	Топ план-1 (Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, зам, талбай)	10.56	0.44
7	Археологийн дурсгалыг авран хамгаалах, малтлага судалгааны ажлын зардал	0.03	0.00
8	Байгаль орчин хамгаалах ажлын зардал	2.02	0.08
БҮГД ӨРТӨГ		2,384.01	100.00

Эх сурвалж: “Туулын хурдны зам”-ын ТЭЗҮ, Урьдчилсан зураг төсөл төсөв.

3.28 Төслийн барилгын ажлын төсөвт өртгийн нэгдсэн товчооны 3, 4, 5 дахь 3 ажлын 89.9 тэрбум төгрөгт магадлал хийгдээгүй, 10.5 тэрбум төгрөгийн 1 ажлыг 2016 оны магадлалын дүгнэлтийг үндэслэн төсөвт өртгийн нэгдсэн товчоонд оруулан тооцсон байна. Үүнд:

- Авто замын трасст орсон ус хангамж, дулаан хангамж, ариутгах татуургын барилгын ажилд 6.5 тэрбум төгрөг,
- Авто замын гэрэлтүүлэг, авто замын трасст орсон ЦШС-г хамгаалах, шилжүүлэх, дэд станц шилжүүлэх, шинээр барих ажилд 28.0 тэрбум төгрөг,
- Мэдээлэл холбооны төлөвлөлт, холбооны сувагчлал, кабель шилжүүлэх, шинээр барих, RFID систем, камержуулалд, тоног төхөөрөмж, программ хангамжийн ажилд 55.3 тэрбум төгрөг,
- урьдчилсан зураг төсвийн барилгын ажлын төсөвт өртгийн нэгдсэн товчоонд “Толл плаза-1” барилгын ажлыг ЗТХТ ТӨҮГ-ын 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 067/2016 тоот МЭД үндэслэн төслийн тооцоонд тусгасан байна,

3.29 Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29^{1.2.2}⁵⁸, Барилгын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4⁵⁹, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 6.8.2⁶⁰-т заасантай тус тус нийцэхгүй байна.

3.30 Барилгын ажлын төсөвт өртгийн нэгдсэн товчоонд туссан тусгай багц ажлуудад магадлал хийж, дүгнэлт гаргуулах, “барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, зам талбайн ажлын төсөвт өртгийг шинэчлэн тооцож магадал хийх шаардлагатай байна.

Урьдчилгаа төлбөрийн баталгааны талаар

3.31 “Туулын хурдны зам” төслийн гүйцэтгэгч гадаад улсад бүртгэлтэй “Чайна Хайвэй Групп Лимитэд” компанийн урьдчилгаа төлбөрийн баталгаанд баталгаа гаргагч гадаад улсад бүртгэлтэй “Жианбанг Инженеринг Перформанс Гарант (Шаньдунг) компани, тус компанийн нэрийн өмнөөс захиалагчтай харилцах, мэдэгдэл хүлээн авах эрх бүхий этгээдээр “Мөнх даатгал” ХХК-ийг сонгосон байна.

3.32 Аудитын гүйцэтгэлийн үе шатанд энэхүү асуудал нь олон нийтийн дунд маргаан дагуулж эхэлсэнтэй холбоотой Санхүүгийн зохицуулах хорооноос тайлбар тодруулга авсан бөгөөд 2026 оны 3/1632 дугаар албан бичигт “...урьдчилгаа төлбөрийн

⁵⁸ Барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаа баталгаажсан төсөвтэй байх,”

⁵⁹ Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээнэ.

⁶⁰ Барилгын тухай хуулийн 34.1.10-т заасны дагуу эрх олгогдсон зураг төсөлд магадлал хийх эксперттэй гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавих;”

баталгаатай холбоотой асуудлыг хуульд нийцсэн эсэхийг тендерийн захиалагч тал болон уг худалдан авах ажиллагаанд хяналт тавих эрх бүхий байгууллага болох Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн худалдан авах ажиллагааны газраас тус тус тодруулах нь зүйтэй” гэж хариу ирүүлсэн байна.

3.33 Мөн урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргагчийн талаар ҮАГ-аас 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн “Мэдээлэл хүсэх тухай” 1305 дугаартай албан бичгийг БНХАУ-аас МУ-д суугаа онц бөгөөд бүрэн эрхэд Элчин сайдад хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй.

3.34 Төслийн гүйцэтгэгч “Хаоюань Женерал Констракшн” ХХК нь 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 350.9 тэрбум төгрөгийг зарцуулсан талаарх мэдээллийг НЗХГ-т 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн НҮМ/2026-25 албан бичгээр хүргүүлснийг аудитад нотлох зүйлээр авсан.

3.35 “Хаоюань Женерал Констракшн” ХХК нь Транс банканд төгрөгийн 9, юанийн 1, ам.долларын 1, Голомт банканд төгрөгийн 2 нийт 13 харилцах данс эзэмшиж байна.

3.36 ҮАГ-ын нэмэлт тодруулгаар 326.0 тэрбум төгрөг, 58.2 мянган ам.доллар, 38.4 сая юанийн үлдэгдэлтэй талаар 2026 оны 06 дугаар сарын 26-ний өдөр ирүүлсэн нь дээрх зарцуулалтын мэдээллээс зөрүүтэй байна.

3.37 Урьдчилгаа төлбөрт олгосон санхүүжилтийн гүйцэтгэлийг зардлын ангиллаар холбогдох баримтын хамт ирүүлэхийг ҮАГ-ын 2026 оны 09/1209 дугаартай албан бичгийг “Хаоюань женерал констракшн” ГХО ХХК-д хүргүүлсэн боловч холбогдох материалыг аудитын хугацаанд ирүүлээгүй тул урьдчилгаа төлбөрийн зарцуулалтын үнэн зөв, бодит эсэхийг баталгаажуулах боломжгүй байна.

3.38 Аудитын явцад урьдчилгаа төлбөрийн баталгаатай холбоотой Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн УЕПГ-ын 2026 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн шийдвэрээр АТГ, ТЕГ, ЦЕГ-ын хамтарсан ажлын хэсэг шалгаж эхэлсэнтэй холбоотой аудитын хангалттай бөгөөд зохистой нотлох зүйл цуглуулах боломж хязгаарлагдаж аудитын иж бүрэн дүгнэлт өгөх боломжгүй болсон тул Төрийн аудитын MNS 6817-5:2020 стандартын 4.2.6, 7.5.1-д заасны дагуу тухайн асуудлыг хязгаарлан аудитын тайланд тусгасан болно.

Газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа газар өмчлөгч, эзэмшигч иргэн, хуулийн этгээдээс төсөл, арга хэмжээний талаарх санал асуулгыг аваагүй байна

3.39 МЕД-ээр “Туулын хурдны зам”-ын ТЭЗҮ-ийг магадлахдаа газар чөлөөлөлтийн зардалд 170.0 тэрбум төгрөгөөр тусгаж баталгаажуулсан байна.

3.40 Тус төслийн нөхөх олговортойгоор газар чөлөөлөх төсөл, арга хэмжээний зардлыг НИТХ-ын тогтоол, ЗД-ын захирамж, Нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг тус тус үндэслэн тухайн онуудад гүйцэтгэлээр санхүүжүүлдэг байна.

3.41 Нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг НИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 24/26 дугаар тогтоол, 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг НИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 25/134 дугаар тогтоолоор тус тус баталсан.

3.42 НИТХ-ын 2024 оны 24/33 дугаар тогтоолоор 2025 оны нөхөх олговрыг 318.5 тэрбум төгрөгөөр баталж 247.7 тэрбум буюу 77.7 хувь, харин НИТХ-ын 2025 оны 25/133 дугаар тогтоолоор 2026 оны газар чөлөөлөх нөхөх олговрын төлбөрийг 205.7 тэрбум төгрөгөөр баталж 105.6 тэрбум төгрөг буюу 51.3 хувийг газар чөлөөлөх, нөхөх олговорт зарцуулсан байна.

Хүснэгт №22. Төсөлд олгосон нөхөх олговрын байдал

Он	Нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө			Үүнээс: “Туулын хурдны зам” мега төсөл /тэрбум төгрөг/	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Гүйцэтгэл	Хувь
2025	318.5	247.6	77.7	0.8	0.3
2026	205.7	105.6	51.3	7.3	14.5
НИЙТ	524.2	353.2		8.1	

Эх сурвалж: НГЗБА-ны санхүүгийн алба /2026.06.05-ны байдлаар/

3.43 “Туулын хурдны зам” төслийн газар чөлөөлөлтийн нөхөх олговор олгож шийдвэрлэсэн 20 нэгж талбараас НЗД-ын захирамжаар 2025 онд 1 нэгж талбарт 0.8 тэрбум төгрөг, 2026 онд 11 нэгж талбарт 7.3 тэрбум төгрөгийг нийт 12 нэгж талбарт 8.1 тэрбум төгрөг олгосон байна.

3.44 Цаашид 8 иргэн, ААНБ-д газар чөлөөлөх нөхөх олговорт 11.4 тэрбум төгрөг олгохоор бэлтгэл ажлыг хангасан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс үзнэ үү/

3.45 Мөн ЗГ-ын 2013 оны “Хурдны зам баригдах талбайн солбицол батлах тухай” 307 дугаар тогтоолоор баталсан трасст аудитын тооцооллоор 30 нэгж талбар давхцаж байгааг тогтоосон бөгөөд 16 нэгж талбарыг чөлөөлсөн байна. Үүнд:

- Байршил шилжүүлсэн – 9 нэгж талбар;
- Нөхөх олговор олгосон - 3 иргэн, ААНБ-д 1.05 тэрбум төгрөг;
- Хянагдаж байгаа - 4 иргэн, ААНБ-д 1.40 тэрбум төгрөг

Хүснэгт №23. 2013 болон 2025 оны трасст өртсөн нэгж талбарын газар чөлөөлөлтийн мэдээлэл, (тэрбум төгрөг)

Дүүрэг	Трасст өртсөн нэгж талбар		Зөрчилтэй нэгж талбар	Чөлөөлсөн байдал					
	2013	2025	2013/2025	Байршил шилжүүлсэн		Нөхөх олговор олгосон		Хянагдаж байгаа	
				Тоо	Хэмжээ/га	Тоо	Дүн	Тоо	Дүн
СХД	41	112	25	6	0.69	2	1.04	4	1.40
БГД			2	1	12.34	1	0.01		
БЗД			2	1	49.69				
ХУД			1	1	0.42				
Нийт	41	112	30	9	63.13	3	1.05	4	1.40

Эх сурвалж: ЗГ-ын 2013 оны 307 дугаар тогтоол, НЗХГ-аас ирүүлсэн трассын зураг,

3.46 Төслийн хэрэгжилттэй холбоотой зарим асуудлыг хууль, хяналтын байгууллага шалгаж байгаа бөгөөд төслийн трасст өөрчлөлт оруулах асуудал шийдвэрлэгдэхээр хүлээгдэж байна. Мөн НИТХ-аар газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж байгаатай холбогдуулан газар чөлөөлөлтийн нөхөх олговрын олголтыг түр хугацаагаар зогсоосон байна.

3.47 Газар чөлөөлөх төслийг хэрэгжүүлэхдээ Санал асуулгын хуудас, Нийгэм, эдийн засгийн судалгаа аваагүй байна. Төслийн трасст өртөж байгаа 112 нэгж талбарт Усан сан бүхий энгийн болон онцгой хамгаалалтын бүс, Ойн тэлэн ургах нөөц болон ойн сан бүхий газар, цахилгаан дамжуулах шугам сүлжээний хамгаалалтын бүс өртөж байгааг нарийвчлан судлаагүй байна.

3.48 Энэ нь НУХЗХТБГХОСтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.4⁶¹-д гэж заасныг мөн ЗГ-ын 2024 оны 91-т тогтоолоор баталсан “Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журам”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.49 ТЭЗҮ-ийн эдийн засгийн шинжилгээний тайланд анхны хөрөнгө оруулалтын өртгийг 1,965.0 тэрбум төгрөг гэж урьдчилан тооцоолсон байна

3.50 Улаанбаатар хотын замын сүлжээний эрэлтийг PTV Visum программаар 2024 онд шинэчлэн боловсруулсан ба “Туулын хурдны зам”-ын 2013 оны ТЭЗҮ-ийн хүрээнд тээвэр төлөвлөлтийн “Жайка Страда” программаар боловсруулсан судалгааны үзүүлэлттэй

⁶¹ Энэ хуулийн 10.3-т заасан дэмжлэгийг авсан тохиолдолд бусад өмчлөгч, эзэмшигчийн газрыг энэ хуулийн 10.7-д заасан журмын дагуу нөхөх олговрыг олгох болон газар албадан чөлөөлөх шийдвэрийг нийслэлийн Засаг дарга гаргана.

харьцуулан гаргаж Эдийн засгийн үр өгөөжийг 2025-2045 он хүртэлх хугацаанд сая ам.доллороор тооцоолон харуулсан байна.

3.51 “Туулын хурдны зам” төслийн хэрэгжих хугацааг 2045 он хүртэл буюу 20 жилээр тооцсон, барилгын ажил дуусаж, ашиглалтад орох хугацааг 2027 он гэж үзсэн байна.

3.52 ТЭЗҮ-ийн хүрээнд төслийн эдийн засгийн болон санхүүгийн дүн шинжилгээний үр дүнг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- Төслөөс бий болох эдийн засгийн өгөөжийн (тээврийн зардлын хэмнэлт) хэмжээ нь 18 жилийн туршид 44.9-191.6 сая ам.доллар болж жил бүр тогтмол өснө,
- Төслийн авто замын засвар арчлалт болон менежментийн жилийн нийт урсгал зардал 6.6 сая ам.доллар,
- Эдийн засгийн үр ашгаас урсгал зардлыг хасаж тооцвол төсөл нь эхний 2027-2030 онуудад 38.3 сая ам.доллар, сүүлийн 2041-2045 онуудад 185.0 сая ам.долларын цэвэр эдийн засгийн үр ашгийг жил тутамд тогтмол оруулахаар байна.
- Төсөл хэрэгжсэнээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөний дундаж хурд 50-90 км/цаг болж өсөх,
- Санхүүгийн дүн шинжилгээний үр дүнгээр 2045 он гэхэд зардал, орлогын тэнцэл +17.54 сая ам.долларт хүрч анхны хөрөнгө оруулалтаа бүрэн нөхөж дуусах боломжтой,
- Зам ашиглалтын хураамжийн төлбөр нь км тутамд 255 төгрөг, тээврийн хэрэгслийн зорчих зам нь дунджаар 2 талдаа нийтдээ 10 км гэж үзвэл өдөрт дунджаар 1 автомашин 2,550 төгрөг төлөхөөр тооцсон нь Хөшигийн хөндийн нисэх буудлын төлбөртэй замын хураамж болох 2,000 төгрөгөөс 550 төгрөгөөр илүү байна.
- Нийслэл Улаанбаатар хотын гол болон туслах гудамж замын “VCR” үзүүлэлт өөрөөр хэлбэл авто замын түгжрэл урьдчилсан тооцооллоор 15 хүртэл хувиар буурах,
- ДҮГНЭЛТ: Эдийн засгийн шинжилгээний хүрээнд хийсэн урьдчилсан судалгаагаар зардал, үр ашгийн харьцаа 1.26 буюу 1-ээс дээш гарсан нь төрийн санхүүжилтээр хэрэгжих боломжтой, төсөл ашигтай гэсэн үр дүн гарсан байна.

Захиалагч төслийн гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллахад анхаарах шаардлагатай байна

3.53 Аудитын явцад ажлын гүйцэтгэлтэй танилцсан бөгөөд захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй НЗХГ-ын мэдээлснээр төсөл 0.173 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Авто зам, авто замын дагуух үерийн хамгаалалтын далангийн барилгын ажил;
- Түр барилга ба үйлдвэрлэлийн бэлтгэл ажил-0.02 хувь
- Замын трасс, талбайн цэвэрлэгээний ажил-0.01 хувь
- Замын чиг сэргээх, гадаслах-0.13 хувь, нийт 0.16 хувийн гүйцэтгэлтэй
- Төмөр бетон нүүр, нүхэн гарцын барилгын ажил
- Түр барилга ба үйлдвэрлэлийн бэлтгэл ажил-0.161 хувь
- Дам нуруу байгуулах ажил-0.012 хувь,

Зураг №6. “Туулын хурдны зам” мега төслийн барилгын ажлын зураг



Эх сурвалж: Аудитын баг

3.54 МУЗГ-ын 2026 оны 68 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотод "Туулын хурдны зам"-ын төсөлд ажиллах гадаад улсын 2150 ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн байна.

3.55 Төлөвлөсөн гадаад улсын 2,150 ажилтан ирэхээс талбайд 133 ажилтан ажиллаж, хүлээгдэж байгаа 2,017 байна. Инженер, техникийн ажилтан зэрэг үндсэн чиг үүргийн ажилтнууд эхний ээлжид ирсэн байна. /Хүснэгт 3-р үзүүлэв./

Хүснэгт №24. Гадаад ажиллах хүчний бэлэн байдал

Үзүүлэлт	Хүний тоо
Нийт төлөвлөгдсөн гадаад ажиллах хүчний	2,150
Талбайд ирээд ажиллаж байгаа гадаад ажилтан	133
Хүлээгдэж байгаа гадаад ажилтан	2,017
Хүсэлт өгсөн тоо	173

Эх сурвалж. "Туулын хурдны зам" 2026.04.01-ний өдрийн төслийн явцын танилцуулга.

3.56 Төслийн бэлтгэл ажлын хүрээнд 234 тоног төхөөрөмж, машин механизмын бэлтгэхээс 89 буюу 38.0 хувийг бэлтгэсэн байна.

Хүснэгт №25. Тоног төхөөрөмж, машин механизмын бэлэн байдал.

Үзүүлэлт	Тоо
Нийт төлөвлөгдсөн машин механизм	234
Талбайд ажиллаж байгаа	89
Ачигдан ирж буй	120
Хүлээгдэж байгаа	25

Эх сурвалж. "Туулын хурдны зам" 2026.04.01-ний өдрийн төслийн явцын танилцуулга.

3.57 "Туулын хурдны зам"-ын зураг, төсөл, худалдан авалт барилгын ажил гүйцэтгэх гэрээний нөхцөлийн 6 хавсралтад "Дотоод нөөц ашиглах шаардлага: 1.4. Гүйцэтгэгч нь төсөлд ашиглах хүний нөөц, машин механизм, худалдан авах бараа материал, ажил үйлчилгээ, тээвэр логикийг доор заасан хувь хэмжээнээс багагүй хувийг Монгол улсын дотоодын зах зээлээс заавал авч ажиллана" гэж заасныг дээрх хувь хэмжээтэй уялдуулан мөрдөн ажиллах нь зүйтэй.

Хүснэгт №26. Монгол Улсын дотоодын зах зээлээс авах хувь, хэмжээ

Д/д	Нэр	Хувь, хэмжээ
1	Ажиллах хүч(удирдлага, мэргэжилтэн, инженер, техникийн ажилтан, бусад ажилтан)	20%-аас багагүй
2	Үндсэн бараа, материал(цемент, арматур г.м)	20%-аас багагүй
3	Машин, механизм	20%-аас багагүй
4	Ажил, үйлчилгээ (катеринг, цэвэрлэгээ зөвлөх үйлчилгээ г.м)	20%-аас багагүй
5	Тээвэр, логистик	20%-аас багагүй

Эх сурвалж: "Туулын хурдны зам"-ын зураг, төсөл, худалдан авалт барилгын ажил гүйцэтгэх гэрээний нөхцөл хавсралт №6-Дотоод нөөц ашиглах шаардлага

3.58 Төслийг тогтоосон хугацаанд, төсөвт өртгийн хүрээнд, ажлын даалгавар, батлагдсан зураг төсөл, холбогдох норм, норматив баримт бичгийн дагуу хэрэгжиж буй эсэхийг шалгах үйл ажиллагаа тодорхойгүй байна.

3.59 НИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 25/153 дугаартай "Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулж, дүрмийг батлах тухай" тогтоолоор Багахангайн мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ыг "Туулын хурдны зам" болгон өөрчлөн байгуулж дүрмийг баталсан байна.

3.60 Дээрх ОНӨААТҮГ өөрчлөн байгуулагдсантай холбоотой 2026 оны 01 дүгээр сарын 27-нд улсын бүртгэлийн гэрчилгээ авч, НЗД-ын 2026 оны Б/129 дүгээр захирамжаар захиргаа санхүү, төсөл, инженерийн 2 хэлтэс, 27 хүний бүтэц орон тоотойгоор баталсан боловч үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй байна.

3.61 Энэ нь Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3⁶², ТХтХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.1⁶³ заалттай нийцэхгүй байх тул “Туулын хурдны зам” ОНӨААТҮГ-ыг өөрчлөн байгуулах, татан буулгах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай байна.

3.62 Нийслэлийн Хяналт шалгалтын газар болон Нийслэлийн байгаль орчны газар нь 2026 онд төслийн хүрээнд хяналт, шалгалтын тодорхой ажил төлөвлөөгүй, Нийслэлийн байгаль орчны газар нь иргэний гомдлоор нэг удаа хяналт, шалгалтыг гүйцэтгэж, тайлагнаснаас өөр тодорхой ажил хийгдээгүй, хяналт хангалтгүй байна.

3.63 Төслийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилсэн тохиолдолд барилгын ажлын техник, технологийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий мэргэжлийн байгууллагыг сонгон зохих хяналтыг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

3.64 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу Ажил, үүргийг гүйцэтгэхтэй холбоотой ажлын талбай дээр ашиглах дараах “Төсөл хэрэгжүүлэх 15 төлөвлөгөөг” боловсруулан хүргүүлснийг захиалагч баталгаажуулсан байна. Үүнд:

1. Төсөл хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөө
2. Зураг төслийн менежментийн төлөвлөгөө
3. Ажлын аргачлалын төлөвлөгөө
4. Чанарын хяналтын төлөвлөгөө
5. Баримт бичиг хянах төлөвлөгөө
6. Ханган нийлүүлэлтийн төлөвлөгөө
7. Гүйцэтгэгчийн удирдлага болон хүний нөөцийн төлөвлөгөө
8. Түр байгууламжийн төлөвлөгөө
9. Сургалтын төлөвлөгөө
10. Төслийн үзүүлэлтийн болон хоног, 7 хоног, сарын мэдээ гаргах төлөвлөгөө
11. Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй болон нийгмийн удирдлагын төлөвлөгөө
12. Тээвэр, логистикийн төлөвлөгөө
13. Ажил гүйцэтгэх төлөвлөгөө, хуваарь
14. Туршилтын төлөвлөгөө
15. Ашиглалтад оруулах, хүлээлгэн өгөх төлөвлөгөө.

3.65 Дээрх 15 төлөвлөгөөг боловсруулсан аргачлал, шалгуур үзүүлэлт тодорхойгүй, зорилгодоо нийцээгүй, хэлбэрийн төдий баримт болсон байна.

3.66 Энэ нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, Авто замын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.4⁵⁷, 21 дүгээр зүйлийн 21.1⁵⁸, ЗТС-ын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-тай тус тус нийцэхгүй байна.

3.67 Төслийн гүйцэтгэлийн явцад захиалагч болон төрийн хяналт шалгалтын байгууллагууд хууль, тогтоомжоор заасан чиг үүргээ хангалттай хэрэгжүүлээгүй, уялдаа холбоо хангагдаагүй нь төслийн чанар, аюулгүй байдалд эрсдэл үүсэж, төсвийн үр ашиг алдагдаж, нийгмийн итгэл буурах нөхцөлийг бүрдүүлж байна.

⁶² Компанийг нэгтгэхээс бусад хэлбэрээр өөрчлөн байгуулж байгаа тохиолдолд шинээр бий болж байгаа компанийг улсын бүртгэлд бүртгэснээр компани өөрчлөн байгуулагдсанд тооцно

⁶³ Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрэгүйгээр шинээр хараат болон охин компани байгуулах;

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Бодлого, шийдвэрийн хүрээнд:

- Улс орны тогтвортой хөгжлийг дэмжих суурь нөхцөл болох дэд бүтцийн томоохон төслүүдийн үр нөлөөг сайжруулах, төсвийг үр дүнтэй зарцуулахын тулд бодлогын баримт бичгүүдийн уялдааг хангаж, төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлэх, хууль, эрх зүйн нийцлийг бүрэн хангах шаардлагатай байна.
- Түлхүүр гардуулах Олон улсын FIDIC гэрээний загварт суурилан зураг төсөл, төсөв боловсруулах, барилга байгууламжийг барих, ашиглах, шилжүүлэх төрлөөр зохицуулах гэрээний нөхцөлийг захиалагч болон гүйцэтгэгч талууд хэлэлцэж, тохиролцсон талаарх баримт байхгүй байгаа нь эрх тэгш харилцан ашигтай байх зарчмыг хангасан хүчин төгөлдөр хэлцэл хийсэн гэж үзэх боломжгүй байна.
- Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, Эрчим хүчний тухай болон бусад хууль тогтоомжид ТЭЗҮ-ийн талаар нэгдмэл ойлголтгүй, Төсвийн тухай хуулийн шалгуурыг хангуулах, зөвшөөрөл авах зорилгоор боловсруулан батлуулж байгаа нь төслийн зорилгод чиглэх суурь баримт бичгийн ач холбогдлыг алдагдуулж байна.
- Урьдчилсан зураг төсөл, төсөвт магадлал хийх нь хууль тогтоомжид нийцээгүй, салбар хооронд чиг үүргийн давхардал, ойлгомжгүй нөхцөл байдлыг бий болгож, нарийвчилсан тоо хэмжээ зөрүүтэй, төсөвт өртөгт өөрчлөлт орох, хяналт, хариуцлагын тогтолцоог сулруулсан байна.
- Эрх бүхий байгууллагаас газар зохион байгуулалттай холбоотой гарсан шийдвэрийг хэрэгжүүлээгүй, мэдээллийн нэгдсэн системд бүртгэж, ил тод зохион байгуулаагүйгээс нийтийн эрх ашиг хөндөгдөж, төрөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээ удаашрах, зардал өсөх нөхцөл болж байна.
- Төрөөс хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх, хэлэлцүүлэг зохион байгуулж хэвшээгүйгээс олон нийтийн хяналтын тогтолцоо алдагдаж, ойлголтын зөрүү үүсэж, төрийн үйлчилгээ харилцан уялдаатай, нэгдмэл бодлого төлөвлөлттэй байх зарчим алдагдаж байна.

Төслийн хүрээнд:

- “Туулын хурдны зам” төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлэх зорилготой төлөвлөсөн боловч нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр өөрчилсөн нь бодлого, шийдвэрийн уялдаа, холбоог алдагдуулсан байна.
- Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулаагүй байна.
- Зураг төсөл, ТЭЗҮ-г нарийвчлан тооцох, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тодорхойлох асуудлыг Хот байгуулалтын тухай хуульд нийцүүлэн цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай байна.
- Төслийн ТЭЗҮ дэх суурь судалгаа болох нийгэм, эдийн засаг, байгаль орчны тайланг бодит тооцоо судалгаанд үндэслэн, холбогдох журам, аргачлалын дагуу үнэн зөв боловсруулж, хянан баталгаажуулаагүй байна.
- Эрх бүхий байгууллагаас Байгаль орчныг хамгаалах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, ил тод байдлыг хангаагүйгээс төр, иргэн, аж ахуй нэгж, байгууллагын эрх ашиг хөндөгдөх нөхцөл үүссэн байна.
- Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй “Туулын хурдны зам” төсөл нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй байна.

- “Туулын хурдны зам” төслийн төсөвт өртгийн тооцоолол нь урьдчилсан зураг төсөл, инженерийн төсөөлөл, томсгосон тооцоонд үндэслэсэн нь нарийвчилсан зургийн шатанд төсөвт өртөгт өөрчлөлт орох нөхцөлийг бий болгосон байна.
- Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах зорилгоор хяналт шалгалтын ажлыг тухай бүр зохион байгуулж ажиллаагүйгээс хууль хяналтын байгууллагад шалгагдах, төслийн явц зогсох, төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилт хангагдахгүй байх, төслийн арга хэмжээнд хугацаа алдаж, удаашрах нөхцөл болж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

- Эдийн засгийн болон дэд бүтцийн салбарын холбогдох хуулиудад “зураг төсөл” гэсэн ойлголтыг нэгдсэн байдлаар тодорхойлж, техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийн агуулга, шалгуур, үнэлгээний аргачлалыг тодорхой болгож, энэ талаарх салбар хоорондын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, холбогдох хууль, эрх зүйн орчныг сайжруулах.

Монгол Улсын Засгийн газарт:

- Улсын хэмжээнд хэрэгжиж буй стратегийн ач холбогдолтой дэд бүтцийн томоохон төсөл хөтөлбөрийн төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилтэд хамаарах эрх зүйн баримт бичгүүд болон Засгийн газраас батлан гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хүчинтэй байдал, залгамж чанараар эрэмбэлж, хуульд нийцүүлэн дахин нягталж, хариуцлага тооцох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Авто зам, замын байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд Зөвшөөрлийн тухай хуульд заасан шаардлагаас гадна мэргэжлийн хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг илтгэх нэмэлт шаардлагыг тавих эрх зүйн баримт бичгийг боловсруулан батлаж, мөрдүүлэх;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын *“Нийслэл Улаанбаатар хотын зүүнээс баруун чиглэлд хэвтээ тэнхлэгийн “Туулын хурдны зам”-ын барилга угсралтын ажлын урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл батлах тухай”* хамтарсан шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу дахин хянан үзэх.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад:

- Барилгын хөгжлийн төв ТӨҮГ нь “Туулын хурдны зам” төслийн техник, эдийн засгийн үндэслэл, урьдчилсан зураг төсөвт 2025 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн 316/2025 дугаартай магадлалын дүгнэлтийн нэгтгэл гаргахдаа барилгын ажлын төсөвт өртгийн нэгдсэн товчоонд туссан зарим ажилд төсвийн эксперт магадлал хийгээгүй байхад дүгнэлт гаргасан шалтгаан нөхцөлийг тодруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох.

Зам, тээврийн сайдад:

- Авто зам, замын байгууламжийн техникийн болон нарийвчилсан зураг төсөлд дүгнэлт гаргахдаа холбогдох хууль тогтоомж, норм дүрэмд нийцүүлэн дахин магадлал хийж, хяналт тавих.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдад:

- Төслийн ТЭЗҮ-ийн бүрдэл дэх нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгааны тайланг бодит тооцоо судалгаанд үндэслэн холбогдох журам, аргачлалын дагуу хянаж, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулж, олон нийтэд нээлттэй танилцуулж хэвших;
- Мэргэжлийн зөвлөлийн ажиллах дүрэм, шинжээчийн үүрэг хариуцлагыг тодорхой болгож, тайлангийн чанар, үр дүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах, нарийвчилсан зураг баталгаажсаны дараа хуульд заасны дагуу байгаль орчинд нөлөөлөх нарийвчилсан үнэлгээний тайланг хянан магадлах, нэмэлт тодотгол хийх.


Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагад нийцүүлэн батлах, төсвийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд тавих хяналтын тогтолцоог сайжруулах.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид:

- “Туулын хурдны зам” төслийн замын чиг (трасс)-ийг тогтоосон асуудлаар судалгаа, тооцоог дахин хийж эцэслэн шийдвэрлэх;
- “Туулын хурдны зам” төсөлд хамаарах газар олголт, чөлөөлөлт, төлбөрийн асуудалд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах, газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа газрыг чөлөөлөхдөө “Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журам”-ыг мөрдөж ажиллах, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг дуусгавар болгох, цуцлах, хүчингүй болгох нэгж талбар байгаа эсэхийг дахин нягтлах зэргээр үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Төслийн бэлтгэл ажлын хүрээнд шаардлагатай тусгай зөвшөөрөл, дүгнэлтийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх;
- Төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр баталсан шийдвэр хүчин төгөлдөр хэвээр байхад төсвийн эх үүсвэр, санхүүжилтийн хэлбэрийг өөрчилдөг байдлаас татгалзаж, хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Урьдчилгаа төлбөрт олгосон санхүүжилтийн гүйцэтгэлийг хянан нягталж, зарцуулаагүй үлдэгдлийн тооцоог гаргаж, бүх шатанд ил тод, нээлттэй мэдээлэх;
- Засгийн газрын 2013 оны 307 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй, төслийн трасст газар олгох шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтнуудад хариуцлага тооцох, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх.

Хавсралт №1. Засгийн газрын 2013 оны 307-р тогтоолтой давхацсан трасс



Хавсралт №2. ТЭЗҮ-ийн төсөвт өртгийн үзүүлэлтийн зөрүү

АВТО ЗАМЫН ХӨГЖЛИЙН ТӨВ /ТЭЗҮ/				БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ /ТЭЗҮ/			
№	Замын хэсгийн нэр	Төсөвт өртгийн нэгдсэн товчоо /төсөвчин хянасан 2016.05.17/	Төсөвт өртгийн нэгдсэн товчоо /төсөвчин хянасан 2024.11.19/	№	Замын хэсгийн нэр	Төсөвт өртгийн нэгдсэн товчоо /төсөвчин хянасан 2025.02.10/	Төсөвт өртгийн нэгдсэн товчоо /төсөвчин хянасан 2025.04.07/
1	(-2) - 0 км хэсэг	16.6	25.8	1	Авто зам, авто замын дагуух үерийн хамгаалалтын далангийн барилгын ажлын төсөвт өртөг	749.4	687.1
2	0 - 9 км хэсэг	109.7	143.5				
3	9 - 14.2 км хэсэг	103.4	170.4				
4	14.2 - 21 км хэсэг	107.3	174.1	2	Төмөрбетон гүүр, туннелийн барилгын ажлын төсөвт өртөг	1,112.9	1,594.5
5	21 - 33 км хэсэг	129.1	218.4	3	Авто замын трассд орсон ус хангамж, дулаан хангамж, ариутгах татуургын ажлын төсөвт өртөг	6.5	6.5
6	Сонсголонгийн 0.32 км хэсэг	2.9	4.1	4	Авто замын гэрэлтүүлэг, авто замын трассд орсон ЦШС-г хамгаалах, шилжүүлэх, дэд станц шилжүүлэх, шинээр барих ажлын төсөвт өртөг	28.0	28.0
7	Ажилчны уулзварын 0.8 км хэсэг	51.0	64.0				
8	110кВ шугам	9.4	9.4				
9	Телекамер	3.1	3.1	5	Мэдээлэл холбооны төлөвлөлт /холбооны сувагчлал, кабель шилжүүлэх, шинээр барих RFID систем, камержуулалт, тоног төхөөрөмж, программ хангамж/-ийн ажлын төсөвт өртөг	55.3	55.3
10	Тохижилт	15.1	17.3				
11	Ажилчны уулзварын Дулааны 106 гог шугам	0.5	0.5				
12	35кВ-ын ЦШС-г кабель шугам болгох	0.3	0.3	6	Толл плаза-1 (Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, зам, талбай)	10.6	10.6
13	Бохир усны даралттай шугам	0.3	0.3				
14	Толл Плаза-1 (Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, зам, талбай)	10.6	10.6				
15	Толл Плаза-2 (Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, зам, талбай)	9.6	9.6	7	Археологийн дурсгалыг авран хамгаалах, малтлага судалгааны ажлын зардал	0.0	0.0
16	Туулын хурдны замын Их Монгол улсын гудамжтай холбох 2 түвшний уулзвар, холбоос зам, туннел	26.0	65.0	8	Байгаль орчин хамгаалах ажлын зардал	2.0	2.0
БҮГД ӨРТӨГ		594.9	916.3	БҮГД ӨРТӨГ		1896.8	2,316.1

Хавсралт №3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд илэрсэн алдаа зөрчил

№	Төрөл	Товч утга
1	Хөрс	БОМТ-д хөрс сайжруулалт, бохирдсон хөрсийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө байхгүй;
2	Ургамал	Хууль, эрх зүйн орчныг тусгасан боловч хүчингүй болсон “Ургамал хамгааллын тухай хууль”-ийг ашигласан, БОНБУ-ний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10-т “Байгалийн ургамлын хууль”-ийн 3 дугаар зүйл зэрэг ургамал хамгаалахтай холбоотой чухал заалтуудыг орхигдуулсан; Төслийн үйл ажиллагаанаас биологийн олон янз байдал, голын татам, ус намгархаг экосистемд үзүүлэх эрсдэлийг ОУ-ын гэрээ, конвенцын хүрээнд бүрэн үнэлээгүй, 32 км үргэлжилсэн, 100 гаруй га талбай бүхий судалгааны бүсэд 9 зүйл ургамал тодорхойлсон нь хангалтгүй, бүртгэсэн ургамлын зүйлүүдийн латин болон монгол нэршил, ангилал зүйн мэдээлэл алдаатай, зарим тохиолдолд ургамлын зүйлийн оронд бүлгэмдлийн нэр ашигласан, экологийн болон ангилал зүйн тайлбаруудыг буруу бичсэн, нөхөн сэргээлтэд тухайн бүсэд ургах боломжгүй болон экологи, амьдрах орчны хувьд тохиромжгүй ургамлын зүйлүүдийг санал болгосон нь судалгааны мэргэжлийн түвшин, өгөгдлийн найдвартай байдлыг хангахгүй; Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн үнэлгээнд барилгын үеийн шууд нөлөөллийг тусгасан боловч авто замын ашиглалтын үеийн урт хугацааны болон хуримтлагдах экологийн нөлөөллийг хангалттай үнэлээгүй, Тухайлбал, “ашиглалтын үед ургамлан нөмрөгт нөлөөлөлгүй” гэж дүгнэсэн нь тоосжилт, амьдрах орчны хуваагдал, харь ургамлын тархалт, гидрологийн өөрчлөлт зэрэг замын экосистемд үзүүлэх урт хугацааны нөлөөллийг орхигдуулсан; Ургамлан нөмрөгийн экологи-эдийн засгийн хохирлын үнэлгээг бодитой бусаар тооцсон;
3	Ой	Төлөв байдалд моддын дундаж нас, насны анги, өтгөрөл, бонитетийн анги, моддын ишний эзлэхүүн, ойн нөөц гэх мэт зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүдийг тусгаагүй, зөвхөн дундаж өндөр, диаметр болон ойн бүрэлдэхүүнийг тодорхойлсон нь ойн сангийн экологийн болон эдийн засгийн үнэлгээ бодит бусаар тооцох эрсдэл үүссэн; Ойн төлөв байдлыг тодорхойлох насны бүтэц, сэргэн ургалт, өтгөрөл, моддын эрүүл мэндийн байдал, доройтол зэрэг үзүүлэлтүүдийг үнэлсэн боловч ойн төлөв байдлыг үнэлээгүй; Зам тавихад өртөх бургас, улиасан ойн экологи-эдийн засгийн үнэлгээг батлагдсан аргачлалын дагуу бодитой тооцоогүй; “Мод суулгах зөвлөмж” нь бүхэлдээ үг үсэг, техникийн алдаатай, утга найруулгын хувьд ойлгомжгүй, “Зааварчилгааны гарын авлага”-д ногоон байгууламжид том хэмжээний нарс модыг шилжүүлэн суулгахаар оруулсан байгаа нь оновчгүй;
4	Усан орчин	Гол трассаас бусад хэсгийн нарийвчилсан зураг төсөл тайланд тусгагдаагүй, голын дотор болон голын татамд гүүрэн байгууламжийн хэдэн тулгуур байрлуулах, ямар гүнд суулгах, барилгын ажлын явцад ус зайлуулах эсэх, түүнээс үүдэх нөлөөллийг тодорхойлоогүй, Жишээлбэл, ус зайлуулах цэгүүдээс хэр зайд усан хангамжийн худаг байгаа, түүнээс хэр хэмжээний ус олборлодог, ус шавхалтаас үүдэлтэй түвшин бууралт үүсэх эсэх, шавхалтыг хэдий хугацаанд хийх, ямар хэмжээний ус шавхах эсэх талаар тусгаагүй; Усан орчны нөлөөллийн үнэлгээнд ихэвчлэн хог хаягдлын нөлөөгөөр усны чанар доройтох талаар дурдсан ба бусад чухал нөлөөллүүд (тухайлбал Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрт нөлөөлөх, газрын доорх усны түвшин, зам барилгын үеийн түр усны зохицуулалт) орхигдсон; Зам, гүүрний ажлаас үүсэх гол “газрын доорх болон гадаргын усны нөөц, горим, чанар өөрчлөгдөх” нөлөөллийг шинжлэх ухааны үндэслэлтэй, тоон баримт, судалгаанд тулгуурлан нарийвчлан үнэлээгүй, Тухайлбал, газрын доорх усны түвшний өөрчлөлт, ялангуяа ус хангамжийн худгуудад, барилгын ажлын ус зайлуулалт болон тэдгээрийн харилцан нөлөөллийг тодорхойлоогүй; Усны эх үүсвэр яг хаанаас хангах нь ойлгомжгүй, усны хэрэглээний тооцоог хэт ерөнхий хийсэн, хоногт ашиглах усны хэмжээ, барилгын ажлын үе шат тус бүрийн хэрэгцээ, усны эх үүсвэрийн хүчин чадалтай уялдсан нарийвчилсан тооцоо дутуу; Усны нөөцийн эх үүсвэрийн ойлгомжгүй байдал нь Туул голын ус ашиглалттай холбоотой зохицуулалтын эрсдэл үүсэх магадлалтай байна. Усны тооцооны хэсэгт ус дамжин өнгөрөөх нүхэн гарцын хийц, байршлын зураг оруулсан боловч түүний зорилго, усны нөлөөллийн ямар асуудлыг шийдвэрлэхээр тусгасан нь тодорхойгүй бөгөөд тэдгээрийн гидрологийн зорилго (ус нэвтрүүлэх, үерийн урсац зохицуулах, замын ус зайлуулах системтэй уялдах гэх мэт) тодорхой тусгагдаагүй; Үерийн далантай холбоотой нөлөөллийн хэсэгт гүүрний суурь хийгдэх байршлууд болон завсрын тулгуурын хийцийн талаар дурдсан боловч тэдгээрийг оруулсан зорилго, ямар байгаль орчны нөлөөллийг тодорхойлох, үнэлэх гэж байгааг тодорхой тайлбарлаагүй; Ахуйн хэрэглээний бохир ус нь гадаргын болон газрын доорх усны чанарт сөрөг нөлөөлөл үзүүлнэ” гэж ерөнхий байдлаар дурдсан боловч тухайн нөлөөлөл ямар байдлаар үүсэх, ямар бохирдуулагч бодисууд (азот, фосфор, эмгэг төрүүлэгч, тос тосолгоо гэх мэт) дамжин нөлөөлөх талаар тодорхойлоогүй; Бохир усны эх үүсвэр, хоногийн хэмжээ, бохир усыг цуглуулах ба зайлуулах систем, цэвэрлэх байгууламжийн шийдэл огт тусгагдаагүй; Усан орчны нөлөөллийн үнэлгээг “Гадаргын усны урсац”, “Гадаргын усны нөөц”, “Гадаргын усны ус хурах талбай”, “Гүний усны хомсдол” гэсэн 4 ерөнхий бүлгээр үнэлсэн боловч эдгээрийн дотор ямар дэд нөлөөллүүд, ямар хэмжүүр, шалгуур үзүүлэлт, ямар тооцоолол ашигласан нь тодорхойгүй байна.

	Тухайлбал “Гадаргын усны урсац” гэсэн үнэлгээнд урсцын хурд, усны горим, үерийн давтамж, сувгийн өөрчлөлт, инженерийн байгууламжийн нөлөөлөл зэрэг ямар бүрэлдэхүүн багтсан нь тайлбарлагдаагүй; Оноот үнэлгээний аргаар усны нөлөөллийг үнэлэхдээ “Гадаргын усны чанарын өөрчлөлт”, “Газрын доорх усны нөөц”, “Ундны усны чанар, хэмжээ” гэсэн ерөнхий нэршлээр үнэлсэн байх бөгөөд эдгээрийн дотор ямар тодорхой нөлөөллүүд (жишээ нь бохирдлын эх үүсвэр, урсцын өөрчлөлт, нөхөн сэлбэлт буурах гэх мэт) орсон нь тайлбарлагдаагүй, Тухайлбал гадаргын усны хувьд зөвхөн чанарын өөрчлөлтөөр хязгаарласан эсэх, эсвэл усны горим, урсцад нөлөөлөх эсэхийг тодорхойлоогүй; Газрын доорх усны нөөц болон ундны усны чанар, хэмжээнд төслийн аль үйл ажиллагаа хэрхэн нөлөөлөх нь тодорхойгүй; Гадаргын болон газрын доорх усны харилцан хамаарлын үнэлгээ хийгдээгүй, Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх, Булаг шандын усны горимд өөрчлөлт орох ба хатаж ширгэх аюултай эсэх, голын голдирол эвдэж өөрчлөх эсэх, Байгалийн эрдэс баялгийг ашиглах эсэх талаар ямар ч нөлөөлөл үзүүлэхгүй гэж дүгнэсэн ч үндэслэл, судалгаа шинжилгээ тусгагдаагүй; Энэ нь гидрогеологийн нөхцөл болон инженерийн шийдэлтэй уялдаагүй, нотолгоо хангалтгүй, уст давхаргад үзүүлэх нөлөөллийг дутуу үнэлснээр барилгын үед усны түвшин буурах, ойролцоох худгуудын нөөц багасах, урсгалын чиглэл өөрчлөгдөх, хөрсний тогтвортой байдал алдагдах зэрэг эрсдэл үүсч болзошгүй; Усан орчинд үзүүлэх нөлөөлөх байдлын үнэлгээг дүгнэхдээ төслийн ашиглалтын үед гүний усны нөөцийн хомсдол үүсэхгүй гэжээ. Энэ нь Усны нөөц, суурь урсцад үзүүлэх нөлөөллийн тооцоогоор Туул голын суурь урсцыг тэтгэх усны хэмжээ жилд ойролцоогоор 8.6 мянган м³-ээр буурахаар байна гэсэн дүгнэлттэй нийцээгүй; Газрын доорх усны чанарыг авч үзээгүй;
--	---

Хавсралт №4. Газар чөлөөлөлтийн судалгаа, сая төгрөг

Д/Д	Нэгж талбарын дугаар	Үндсэн талбайн хэмжээ /м2/	Захирамжийн огноо, дугаар	Нөлөөлөлд өртсөн газрын		Хөрөнгийн нөхөх олговрын үнэлгээ		Нийт нөхөх олговор
				Хэмжээ /м ² /	Үнэлгээ	Үл хөдлөх хөрөнгө	Эд хөрөнгө	
Олгосон								
1	1801603659	44098	НЗД-ын 2025.11.11 А/1586	9170	821.63	-	-	821.63
2	1801602364	9990	НЗД-ын 2026.02.12 А/219	-		-	39.33	39.33
3	1801602741	9990	НЗД-ын 2026.02.12 А/219	-		-	52.61	52.61
4	1801603212	9943	НЗД-ын 2026.04.08 А/520	9943	927.85	-	131.81	1,059.67
5	1801603213	9931	НЗД-ын 2026.04.08 А/520	9931	889.82	-	103.27	993.09
6	1801603818	2796	НЗД-ын 2026.04.08 А/520	2796	250.52	-		250.52
7	1801603611	19985	НЗД-ын 2026.04.08 А/520	8000	716.80	-	34.84	751.64
8	1801604369	10715	НЗД-ын 2026.04.08 А/518 НЗД-ын	10715	960.06	-	-	960.06
9	1681910189	7000	НЗД-ын 2026.06.04 А/830	1319	-	-	10.55	10.55
10	1801603785	19984	НЗД-ын 2026.06.04 А/830	3586	491.60	-	27.45	519.05
11	1801603104	699	НЗД-ын 2026.06.04 А/830	402	11.25	329.70	103.25	444.21
12	1801601700	59952	НЗД-ын 2026.06.04 А/830	8865	1,216.42	813.21	143.70	2,173.32
Нийт		205083		64727	6,285.96	1,142.91	646.80	8,075.67
Хянагдаж байгаа								
1	1801603530	5000	-	5000	448.00	-	38.23	486.23
2	1801604193	10009	-	10009	896.81	-	-	896.81
3	1801604244	37389	-	8924	1,223.37		140.12	1,363.49
4	1801604264	69670	-	2552	328.29	7,157.99	616.93	8,103.20
5	1801604413	700	-	700	19.61		25.85	45.46
6	1801604293	700	-	700	19.61	312.37	100.51	432.49
7	1801604292	700	-	700			25.67	25.67
8	1801604291	700	-	700			43.67	43.67
Нийт		124868	-	29285	2,935.69	7,470.35	990.98	11,397.02



Газар чөлөөлөлт, Түүхчилсэн
судалгаа, Хориглолт, хязгаарлалт,
хамгаалалтын бүсэд давхацсан нэгж
талбарын дугаар, тоо
Хавсралт №5,6,8



Төслийн ажил гүйцэтгэхэд
шаардлагатай авсан
зөвшөөрөл
Хавсралт №7



Аудитад шалгагдагч
байгууллагаас тайлангийн
төсөлд ирүүлсэн саналын
нэгтгэл


ИРҮҮЛСЭН САНАЛ




НЗДТГ



НХААГ




НЗХГ



УСНЫ ГАЗАР



НГЗБА



ГЗБГЗЗЕГ



ЗТХТ



БОУАӨЯ